

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЭКО-ЭРҮҮЛ ДҮҮРЭГ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 08

Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнтгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ												
1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эко бичил цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Нийтийн эзэмшлийн талбайд бичил цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Нийслэл, Дүүргийн төсөв	3,200.0	8 бичил цэцэрлэгт хүрээлэн, 168 тоглоомын талбай.	2-оос доошгүй бичил цэцэрлэгт хүрээлэн, 4-өөс доошгүй тоглоомын талбай байгуулсан байна.	800.0	НТХО 10,795.6 ДТХО 3,909.5 ААНБ 2,542.0	Иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх, амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн төсөв, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд 15 хорооны 24 байршилд цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгт хүрээлэн тохижилт, тоглоомын талбайн ажил хийгдэхээс Төрийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд 15 байгууламж бүхий "Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төсөл хэрэгжиж 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 3.47 га талбайд эхлэж талбай байгуулж, мод, зүлэг шинээр тарьж тохижуулсан. Мөн яармагийн 4-8, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт туул голын эрэг дагуу 149,1 талбайд Улаанбаатар групп ХХК-тай хамтран "Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн" байгуулах "Tuul urban" төсөл хэрэгжүүлэхээр зураг төсөл боловруулахад хамтран ажиллаж байна. 2, 12, 20, 21 дүгээр хороодод хэрэгжүүлсэн ногоон байгууламж, спорт талбай, тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж, тохижилтын бусад элемент бүхий бичил цэцэрлэгжүүлэлт, тохижилтын ажил дуусаж ашиглалтад хүлээн авсан. 1, 2, 3, 10, 11, 15, 16, 17, 18, 20, 21, 24 дүгээр хороодын 18 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тоглоомын талбайн ажлуудаас 1, 2, 10, 11, 15, 16, 17, 21, 24 дүгээр хороодод хэрэгжүүлсэн 14 толоомын талбайн тохижилтын ажил дуусаж ашиглалтад хүлээн авсан. 17, 18, 21, 24 дүгээр хорооны тоглоомын талбайн ажил он дамжин хэрэгжинэ.	100%
	2	Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх аян зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х	-	-	"Манай хороо - Миний гудамж" аяныг зохион байгууллагуудын оролцоотойгоор тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 29 байршилд тоглоомын талбай, 6 байршилд цэцэрлэгт хүрээлэн 7175м2 явган зам болон 1600м/урт дугуйн замыг хийж гүйцэтгэсэн.	"Манай хороо - Миний гудамж" аяныг зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоотойгоор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/180 дугаар тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/485 дугаар захирамжаар зохион байгуулсан "Манай хороо – Миний гудамж" арга хэмжээний шалгаруулалтад дүргээс 7 хороо, 4 аж ахуйн нэгж, байгууллага, 1 өрх, хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний 4 байгууллага тус тус оролцож тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Аяны нэгдсэн шалгаруулалтад амжилттай оролцож, "Шилдэг дүүрэг" номинацийн дэд байр, "Шилдэг хороо" номинацийн тэргүүн /1-р хороо/, тусгай байр /16-р хороо/, "Шилдэг аж ахуйн нэгж, байгууллага номинацийн тэргүүн байр /Юнитра ХХК/, "Шилдэг ерх номинацийн 3-р байр /12-р хороо, иргэн Энхтуяа/, "Шилдэг зам цэвэрлэгээний байгууллага" номинацийн тусгай байр /Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул Агро ОНӨААТҮГ/, шилдэг хог тээврийн байгууллага /Эко хотын тээвэр ОНӨААТҮГ/, Шилдэг СӨХ номинацийн 1, 2, тусгай байр /Шинэ өглөө СӨХ, Ака 1 СӨХ, Вива сити хороолол СӨХ/-ийг тус тус эзэлсэн.	100%
	3	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг тоолж, бүртгэж мэдээллийн сан үүсгэж, баяжуулж ажиллана.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	9.9	-	Шинээр хийгдсэн ногоон байгууламжийг бүртгэлжүүлж, мэдээллийн сангийн баяжилтыг 50% -д хүргэнэ.	-	-	-	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/61 дүгээр захирамжийн хүрээнд 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг ургамлын төрөл зүйлээр нь ангилж, нарийвчлан судалж, тоолж, бүртгэлжүүлж газарзүйн мэдээллийн системд суурилсан орон зайн цахим мэдээллийн санг үүсгэсэн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас нийслэлийн хэмжээнд газарзүй мэдээллийн системд суурилсан ногоон байгууламжийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажил хэрэгжиж байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд нэгдсэн загвар бий болсны дараа дүүргүүд ногоон байгууламжийн мэдээллээ оруулна. "Ногоон хот-Иргэний оролцоо" мод тарих аяны хүрээнд тарьсан 260361 ширхэг мод, бут, сөөгийг бүрэн бүртгэлжүүлсэн.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.1.2 Туул, Дунд голыг түшиглэн иргэд 4 улирлын турш амарч, зугаалах зориулалт бүхий тохилог орчныг бүрдүүлнэ.	4	Туул, дунд голын дагуу байршилд иргэдийн амарч, зугаалах бүс байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Нийслэл, дүүргийн төсөв	3,000.0	3 амралт зугаалгын бүс байгуулсан.	1-2 байршилд амралт зугаалгын бүс байна.	1,000.0	ДТХО 867.5	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 15 дугаар хороо Төв цэнгэлдэх хүрээлэн орчмыг тохижуулах ажлын хүрээд 18100 м.кв талбайг зүлэгжүүлж, шинээр 77 ширхэг нарс тарьж цэцэрлэгжүүлж, 5907 м.кв талбай бүхий авто зогсоолыг шинэчилж, 1074 м.кв талбайд тойрог замын болон амралтын талбайн бетон цутган, тэмжээвэр амьтад салхилуулах зориулалт бүхий талбай болон бусад тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хороо Дунд гол дагуу 7, 8 дугаар байр, 12 дугаар хороо Малчны хэсэгт Туул дагуу тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбай бүхий иж бүрэн тохижилтын ажлыг хэрэгжүүлсэн. Дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 2022-2031 онд 5 үе шаттайгаар 149 га талбайд Туул урбан парк хэрэгжих Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн /Family Garden/ төсөл зураг төсөл боловсруулагдаж, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх шатанд хэрэгжиж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/74 дүгээр захирамжийн хүрээнд 13 дугаар хорооны 7 дугаар хэсэгт Туул гол дагуу 3 га талбайд ойн төгөл бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах тохижилтын ажлын зураг төсөл боловсруулж, батлуулсан.	100%
1.1.3 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5	"Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг тооцно.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	200.0	-	Хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувь.	-	-	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 зорилт 10 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 7 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 81.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 43 байршилд иргэд, олон нийтэд зориулсан тохижилт, ногоон байгууламж бүхий талбай, тоглоомын талбай, спорт талбай /3x3 сагсан бөмбөгийн талбай хөлбөмбөгийн талбай/ байгуулах, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах, 260361 ширхэг мод, бут, сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 267,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах, 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн.	90%
	6	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор "Бүх нийтээр мод тарих өдөр" арга хэмжээг зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	160.0	Бүх нийтээр мод тарих арга хэмжээг 5, 10 дугаар сард зохион байгуулж, 21,841 ш мод бут сөөг тарьсан.	Бүх нийтээр мод тарих 2 удаагийн арга хэмжээгээр 20,000-аас багагүй мод бут сөөг тарина.	40.0	Дүүргийн төсөв 622.9	"Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяны хүрээнд "Ойжуулалт, ойн зурвас байгуулах /14 дүгээр хороо, Айцын ам, 8 га", "Гэр хорооллын өрхүүдтэй хамтарч мод тарих /9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороо", "Нийтийн эзэмшлийн болон хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх", "Мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвас байгуулах" гэсэн үндсэн 4 арга хэмжээгээр 260,361 ширхэг мод, бут, сөөг тарьж, 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хорооны 21 байршилд нийт 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан.	100%
	7	Цэцгийн үрсэлгээ хийх, нийтийн эзэмшлийн талбайд цэцгийн мандал байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	200.0	149,100 цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбайг чимэглэсэн.	200,000-аас доошгүй цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбай чимэглэнэ.	50.0	Дүүргийн төсөв 70.0	Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ Чингисийн өргөн чөлөөний авто замын 5 бульварт нийт 1800 ширхэг гоёл, чимэглэлийн байцаан цэцэг тарьсан. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжийн дагуу 10 төрлийн гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд 267519 цэцэг тарьж цэцгийн мандал байгуулах ажлыг хэрэгжүүлж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна. Нийт 269319 ширхэг гоёл, чимэглэлийн цэцэг тарьсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн хувь	
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.2. Агаар, орчны бохирдол												
1.2.1 Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	8	Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хөвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.	2021-2024	ТНБХХУ Х, МХХ	-	-	3 хангамжийн бааз, 57 борлуулалтын цэг байгуулсан.	1 хангамжийн бааз, 55-аас доошгүй борлуулалтын цэг ажиллуулна.	-	Дүүргийн төсөв 2.0	2022 онд дүүргийн хэмжээнд галлагааны улиралд сайжруулсан шахмал түлшний 1 хангамжийн бааз, борлуулалтын 53 цэг үйл ажиллагаа явуулж, өдөрт дунджаар 5тн түлш түгээлтээр ирж борлуулагдаж байна. 2022 онд 11 сарын байдлаар 32,147.3 тн сайжруулсан шахмал түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангасан. Дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш нөөцлөх 7 агуулахад 11,120 тн сайжруулсан шахмал түлш нөөцлөсөн. Дүүргийн алслагдсан хороод буюу 13, 14 дүгээр хороодод 2 борлуулалтын цэг нэмж ажиллуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.	100%
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	12	Гэр хорооллын айл өрхүүдийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл хүргэх ажил зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х	-	-	Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг 1-2 удаагийн хүргэх ажлыг 6 удаа зохион байгуулж, гэр хорооллын 17,464 өрхийг хамруулсан.	Угаарын хийн хордлогоос сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг 1-2 удаагийн хүргэх ажлыг зохион байгуулж, 16,000-аас доошгүй өрхийг хамруулна.	-	ДТХО 13.8	2022 оны галлагааны улиралд агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн эрсдэлээс сэргийлэх, дэвшилтэт техник технологийн талаар мэдээлэл өгөх чиглэлээр гэр хорооллын хороодыг 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14 хороодыг 3 бүсэд хувааж 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, зөвлөмж сэрэмжлүүлэг тараасан. 1. 2,3,4 дүгээр саруудад 3 төрлийн 48000ш гарын авлагыг 16000 өрхөд тараах арга хэмжээг зохион байгуулж зөвлөмж сэрэмжлүүлэг мэдээллээр хангасан.	100%
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	13	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	2021-2024	ТНБХХУ Х	-	-	350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 450-аар нэмэгдүүлнэ.	-	УТХО 896.5	Дүүргийн гэр хорооллын "Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага MNS 5924:2015" стандарт бүхий гэр хороолол, зусланд хэрэглэх зориулалттай нүхэн жорлонгийн 4 хувилбарын талаарх мэдээллийг агуулсан 1 видео шторкийг дүүргийн болон хороодын цахим хуудсанд байршуулан иргэдэд хүргэсэн. Дүүргийн гэр хорооллын хороодод барьсан стандартын бус нүхэн жорлон нийт 10475, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж 1304 ширхэг байна. Өмнөх онтой харьцуулахад стандарт бус нүхэн жорлон 3380-аар буурсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хэрэгжүүлж буй Туул гол орчмын хөрсний бохирдлыг бууруулах эко нойлын гүйцэтгэгчээр "Оргил-Өргөө" ХХК шалгарч 8, 9, 10 дугаар хороодод нийт 551эко нойл барихаас 534 ширхэг нойлын нүх ухаж, 164 нүхэнд кольцо суулгаж, 18 ширхэгт нь бүхээг тавьж ашиглалтанд оруулсан.	100%
	14	Нүхэн жорлон, бохирын цооногийг халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	2021-2025	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	266.0	13496 нүхэн жорлон, 8042 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн.	13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооногийг 100% ариутгаж халдваргүйжүүлсэн байна.	66.5	ДТХО 86.6	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/260 дугаар захирамжаар 10475 ширхэг нүхэн жорлон, 5575 ширхэг бохирын цооногийг бохир задлах, үнэр дарах, халдваргүйжүүлэх био бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.	90%
1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инноваци												
	15	"Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлж, тарвасын тариалалтыг дэмжин ажиллана.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж	-	Зуны 3000м2 талбай бүхий хүлэмжид тариалж нийт 1.0 тн ургац хураан авч байна.	Хүлэмжийн талбайг 0.5-аас доошгүй га-аар нэмэгдүүлнэ.	-	-	Дүүгийн хэмжээнд 5.5га талбайд өргөст хэмх тариалж 153тн, 5.1га талбайд улаан лооль тариалж 72.2тн, 3.3га талбайд чинжүү тариалж 45тн, 2.4га талбайд навчит ногоо тариалж 72тн, 2.8га талбайд тарвас тариалж 18.8тн ургац, 4.2га талбайд бусад төрлийн хүлэмжийн ногоо тариалж 5.35тн, нийт 366.5тн ургац хураан авсан. Хүлэмжийн тариалалтын талбай 2021 онд 21га талбай байсан бол 2022 онд 23.3га талбайд тариалалт хийгдсэн нь өмнөх оноос 2.3 га талбайгаар буюу 0.9 хувиар нэмэгдсэн байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.3.1 Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих "Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	16	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийг мэргэжил арга зүйн сургалт, туршлага судлах арга хэмжээнд хамруулна.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн төсөв	4.5	20 иргэнийг сургалтад хамруулсан.	20-иос доошгүй иргэнийг хамруулж хүлэмжийн тариалалтын талаарх мэдлэгтэй болгоно.	1.0	-	Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй иргэдэд мэргэжлийн байгууллагатай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, 157 тариалан эрхлэгч хамрагдсан Үүнд: • Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа сургалт судалгааны төвтэй хамтран "Хүнсний ногооны үр үрслэг хийх агротехнолог"-ийн 2 удаагийн сургалтад хүлэмжийн тариалалт эрхэлдэг 30 газар тариалан эрхлэгч, • Дүүргийн 3-р хороонд байрлах орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн "Фор Ви Ар Грийн" ХХК-ны дээврийн хүлэмжийн аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалтад 20 газар тариалан эрхлэгч, • Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, цахим гарал үүсэл олгох 3 удаагийн сургалтад хүлэмжийн болон ил талбайн тариалалт эрхэлдэг 107 газар тариалан эрхлэгч тус тус хамрагдсан.	100%
	17	Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн төсөв	36.0	20 тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулсан.	20-аас доошгүй тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулна.	9.0	Дүүргийн төсөв 2.7	Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Амралтын өдрийн худалдаа", "Улаанбаатар марафон", "Монгол ногоо-2022", "Намрын ногоон өдөрүүд-2022" зэрэг 8 удаагийн үзэсгэлэн худалдаанд 144 газар тариалан эрхлэгчийг оролцуулж, 939.9 тонн төмс, хүнсний ногоо худалдан борлуулж, 955.1 гаруй сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн.	100%
1.3.2 Газар тариалан эрхлэгчдэд экологийн цэвэр бордоо ашиглах, экологийн цэвэр тариалан эрхлэхэд нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэн "Хан-Уулд тариалав" брэнд бий болгоно.	18	"Хан-Уулд тариалав" брэнд бий болгоно.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	-	4-5 Бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	-	-	"Хан-Уулд тариалав" брэнд болгох зорилтын хүрээнд тарвас, дээврийн хүлэмж, салат навч, яншуй, өргөст хэмх, юуцай, бууцай, гүзээлэгнийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд: • Тарвас тариалах сонирхолтой иргэдийн судалгааг цахимаар авч, тарвас тарих сонирхолтой 64 иргэнд тарвасын ач холбогдол, тарилт, ургалт, хортон шавьжтай тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, тарвасын ашиг тус, шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээлэл бүхий постерыг бэлтгэн холбогдох сайтуудад байршуулсан. • Дүүргийн 13 дугаар хорооны хүлэмжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах, үзэсгэлэн худалдааг Лавай, Фермерүүд, Их наяд худалдааны төвдүүдэд зохион байгуулсан. • Дүүргийн 3-р хороонд байрлах орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн "Фор Ви Ар Грийн" ХХК-ны дээврийн хүлэмжийн аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээгээр хүлэмжийн аж ахуйг байшингийн дээвэр дээр хийх боломжтойг үзүүлж, түүний ач холбогдлыг танилцуулж, хэвлэл мэдээллээр сурталчлан ажилласан. • Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Амаркэтеринг" ХХК, "Монголын эмэгтэйчүүдийн сан"-тай хамтарч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажлын хүрээнд тариалангийн талбайн хамгаалалтын зурвас татах хамтарсан төслийг танилцуулж, 800метр талбайд ойн зурвас байгуулж, 4 улиралд гарах боломжтой өвлийн хүлэмжид тарьж ургуулсан 6 төрлийн нарийн ногоо буюу салат навч, яншуй, өргөст хэмх, юуцай, бууцай, гүзээлэгнийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.3.3 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилна.	19	Бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	ХХҮХ, ЖДУДТ	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	1 арга хэмжээ зохион байгуулж, 20 үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулсан.	30-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг "Хан-Уулд үйлдвэрлэл" сэтгүүлээр сурталчлах ажлыг зохион байгуулна.	-	-	Бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, сурталчлах зорилгоор 3 арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд: 1. Дүүргийн 3-р хороонд байрлах орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн "Фор Ви Ар Грийн" ХХК-ны дээврийн хүлэмжний аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах арга хэмжээг 20 газар тариалан эрхлэгчдийн дунд зохион байгуулсан. Уг арга хэмжээгээр хүлэмжийн аж ахуйг байшингийн дээвэр дээр хийх боломжтойг үзүүлж, түүний ач холбогдлыг танилцуулж ажилласан. 2. Богд банктэй хамтран жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сарын 1.2-1.9 хувийн хүүтэй зээлд дүүргийн шаардлага хангасан 88 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг холбон зуучилснаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 58 иргэн, аж ахуйн нэгж 4.6 тэрбум төгрөгийн зээл авсан байна. 3. "Хан-Уулд үйлдвэрлэл" сэтгүүлийн 2022 оны дугаарын эх бэлтгэлийг бэлтгэж 1200 ширхэгийг хэвлүүлэхээр хэвлэлийн үйлдвэрт өгөөд байна. Уг сэтгүүлд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 60 иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж, олон нийтэд танилцуулна.	100%
1.3.4 Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	20	Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	2022-2024	ААӨХ, ТГУХ	Улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламж	2,500.0	-	Инкубатор төвийн ТЗҮ, зураг төсөв хийгдсэн байна.	45.0	-	Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийн барилга барих саналыг боловсруулан Монгол улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дугаар албан бичгээр, Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06/295 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус хүргүүлэн ажилласан.	0%
1.4. Аялал жуулчлал												
1.4.1 Дүүргийн байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн "Их түүхийн жимээр" аяллын маршрутыг бий болгоно.	21	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн явганаар аялах аяллын маршрут бий болгоно	2021-2024	ХХҮХ, НБХ, ТНБХХУ Х	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	1,000.0	Богд уул руу алхах 1 маршрут	Маршрутын дагуу тохижилтын ТЗҮ, зураг төсөв хийгдсэн байна.	30.0	-	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 11 дүгээр хороо, Богдхан уулын Дугуй цагааны аманд явган аялалын маршрутын дагуу тохижилт хийх ажлын явц 80 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд хүүхдийн модон тоглоом, явган зам, сити 00, тойрог бүхий тохижилтын талбай, терас, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, камержуулалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Улсын төсөвт Богд хаан ууланд явган аялалын маршрут зураг төсөв боловсруулах 400.0 сая төгрөгийн хөрөнгийг тусгуулах санал хүргүүлэн батлуулсан бөгөөд "Богдхан ууланд явган аялалын маршрут"-ын зураг төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Ньюурбанизм ХХК шалгарч зураг төсвийн ажлыг гүйцэтгэж байна. Дүүргийн үрсэл хөгжил, байгаль түүхийн дурсгалт газар болон бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор "Их түүхийн жимээр" аялалын маршрут боловсруулан, маршрутын дагуу 2 удаагийн аяллыг дүүргийн ерөнхий боловсролын 10, 26, 59 дүгээр сургуулийн ахлах ангийн 90 сурагчдад зохион байгуулж, хүүхэд залуучуудад их түүхээ мэдэх, дүүргийнхээ үүсэл хөгжил бүтээн байгуулалтын ажлуудтай танилцах, түүгээр бахархах үзлийг түгээх, дотоодын аялал жуулчлал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдлэг олгосон.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн хувь
								2022 он			
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)	
1.4.2 Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч хүйтний улиралд иргэд олон нийт чөлөөт цагаа өнгөрүүлэх өвлийн баазыг Яармаг, Сонгино, Жаргалантын аманд байгуулна.	22	Хүйтний улиралд иргэд амарч, зугаалах зориулалт бүхий орчныг бүрдүүлнэ.	2022-2024	ТГУХ, ГЗБА, НБХ	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	2,000.0	-	Байршил, газрын судалгаа хийж, өвлийн баазын ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн байна.	60.0	Хүйтний улиралд иргэд амарч зугаалах зориулалт бүхий орчин бүрдүүлэхэд шаардлагатай газрын асуудал шийдвэрлэгдээгүй тул дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 13.5 га газарт хэрэгжих "Эко зуслан" төсөл арга хэмжээ хэрэгжих нэгж талбарт багтаан хэрэгжүүлэхээр зураг төсөл боловсруулж байгаа бөгөөд загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Дээрх төсөл арга хэмжээний хүрээнд зуслангийн 282 зуны сууц, 120 өвлийн сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж төлөвлөгдсөн. "Эко зуслан"-ийн ажлын зураг боловсруулагдаж байна.	70%
1.4.3 Богдхан уулын дархан цаазат газрын биологийн олон янз байдлын судалгаанд үндэслэн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	23	Богдхан уулын байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулан, байгалийн аялал жуулчлал хийх орчин бүрдүүлнэ.	2022-2024	ТНБХХУ Х, ХХҮХ	Улс, Нийслэл, Дүүргийн төсөв	-	-	Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулна.	-	Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас 9 бүлэг 58 хуудас бүхий "Богдхан уулын дархан цаазат газрын 2022-2026 оны менежментийн төлөвлөгөө"-г боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газраар батлуулсан ба дүүргийн зүгээс төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлж хамтран ажиллалаа. Аялал жуулчлал хийх орчин бүрдүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яаманд Богдхан уулын амуудад явган алхалтын маршрут гаргах, тохижуулах санал хүргүүлснээр 382 сая төгрөгийн зураг төсвийн санхүүжилтийг батлуулсан бөгөөд "Богдхан уулын явган аялалын маршрут"-ын зураг төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Ньюурбанизм ХХК шалгарч зураг төсвийн ажлыг гүйцэтгэж байна. Нийт 8, 21, 23, 24 дүгээр хорооны хил заагт хамаарах 7 аманд явган аялалын маршрут гаргахаар төлөвлөн ажиллаж байна.	100%
1.4.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	24	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	2021-2024	ХХҮХ, МХХ	Дүүргийн төсөв, бусад эх үүсвэр	-	1 удаагийн хамтарсан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	2-оос доошгүй удаа хамтарсан үзлэг шалгалтад ААН-үүдийг 100% хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгнө.	-	Дүүргийн нутаг дэвсгэрт зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 35 аж ахуйн нэгжид мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 6 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүнд: 1. Стандарт шаардлагуудыг мөрдүүлэх, галын аюулгүй байдал, ой хэзрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 6 удаа нийт давхардсан тоогоор 138 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 65 зөрчил илрүүлэн 5 зөрчлийг газар дээр нь арилгуулан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 8 албан шаардлага хүргүүлж ажилласан. 2. Хотын стандартыг танилцуулах, иргэдэд амрах аялах таатай нөхцлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 4 удаагийн сургалт уулзалтад 28 аж ахуйн нэгжийг хамруулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг/)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
1.4.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	25	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, ой хээрийн түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2025	ОБХ	Дүүргийн төсөв	-	2 удаагийн сургалт зохион байгуулсан.	2 удаагийн дадлага сургалт зохион байгуулна.	-	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2022 онд 2 удаагийн дадлага сургалтын арга хэмжээг зохион байгуулж 585 албан хаагч, тамирчид, сонсогч нарыг хамруулан зохион байгуулсан. 1. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/232 дугаар захирамжаар батлагдсан "Ногоон бүсийг ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургуулийг" төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 14 дүгээр хороо, Түргэний аманд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн нийт 19 байгууллагын 300 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Мөн дадлага сургуулийн үеэр гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын дунд гал түймэр унтраах сорил дадлагын уралдаан, тэмцээн зарлан нийт 16 багийн 64 тамирчид өрсөлдөн 1 дүгээр байранд "Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮгазар", 2 дугаар байранд "Витафит" ХХК, 3 дугаар байранд "Мөнхийн үсэг" ХХК зэрэг байгууллагууд шалгарч Засаг даргын өргөмжлөлийн эзэд болсон. 2. Улаан загалмайн хорооны сайн дурын идэвхтнүүд түймэрт түлэгдсэн, гэмтсэн иргэдэд анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлэх дадлага сургалт явуулж, дүүргийн Цагдаагийн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид, хорооны Засаг дарга, ажилтнууд, Чингисийн хүрээ аялал жуулчлалын бааз, бусад мэргэжлийн байгууллагууд тус тусын чиг үүргийн дагуу ой хээрийн гал түймэр унтраах дадлага сургалтад оролцож ойн түймэртэй тэмцэх хүч хэрэгслээ тодотгож ажиллалаа. Үг сургалтад Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангиудад дадлага хийж байгаа Хууль сахиулах их сургуулийн Ахлаачийн сургуулийн 32 сонсогч оролцсон. Ногоон бүсийг ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургалтад нийт 189 хүн, 15 техник хэрэгсэлтэй ажилласан. Дүүргийн Засаг даргын "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай" А/467 дугаар захирамжын дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 100 аж ахуйн нэгж, байгууллагад бэлтгэл ажлыг хангуулан ажилласан.	100%	
БҮЛГИЙН ДУНДАЖ ХУВЬ												92%
ХОЕР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ												
2.1. Биеийн тамир, спорт												
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	26	Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр зохион байгуулна.	2021-2024	БТСХ	Дүүргийн төсөв	209.0	Иргэдийн наадамд 3500 иргэн хамрагдсан.	Иргэдийн наадамд 3700 иргэн хамруулсан байна.	52.0	Дүүргийн төсөв 52.0	Иргэдийн спортын X их наадмыг спортын 8 төрлөөр (явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагай наадгай) хороо, дүрэг 2 үе шаттайгаар зохион байгуулж, дүүргийн шилдгээр шалгарсан 200 гаруй тамирчид Нийслэлийн иргэдийн спортын их наадмаас 4 алт, 2 мөнгөн 2 хүрэл нийт 8 медаль хүртэж багийн дүнгээр Тэргүүн байранд шалгарсан. Иргэдийн спортын X их наадамд давхардсан тоогоор 5,880 иргэнийг хамруулсан.	100%
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	27	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, автомашингүй өдөр, спортлог Улаанбаатар өдөрлөг, гүйлт гэх мэт/	2021-2024	БТСХ	Улс, Дүүргийн төсөв	75.0	Нийтийн биеийн тамирын ажиллагаанд 4727 хүн оролцсон.	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 5200-аас доошгүй хүн хамруулна.	20.0	-	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аянд 28636 иргэн, "Улаанбаатар марафон-2022" ОУ гүйлтэд нийт 3014 иргэн, "Автомашингүй өдөр" арга хэмжээнд 3000 иргэн, "Хамтдаа алхаад эрүүлж" аянд 2131 иргэн, Нийслэлийн Засаг даргын санаачлагаар зохион байгуулагдаж буй "Алхацгаа гүйцгээе" явган алхалтад 61 байгууллагын 1870 албан хаагч, ХУД-ийн "УБ лиг" Волейболын фестивальд 950 иргэн, ХУД-ийн ЕБС багш нарын тэмцээнд 1000 багш, Улаанбаатар Марафонд нэгдэцгээе" цом аялуулах аянд 6097 иргэн, Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын аянд 3766 иргэн, Иргэдийн спортын наадамд 5880 иргэн, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан биеийн тамирын 16 арга хэмжээнд 502 иргэн, нийт 92 арга хэмжээнд давхардсан тоогоор 125,286 иргэн хамрагдсан.	100%
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	28	Өвлийн спортын үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2024	БТСХ	Улс, Дүүргийн төсөв	21.0	Өвлийн улиралд зохион байгуулагдсан арга хэмжээнд 3500 хүн хамрагдсан.	Оролцогчдын тоог 3800-аас доошгүй хүн хамруулна.	5.0	-	Дүүргийн хэмжээнд өвлийн спортын чиглэлээр биеийн тамирын "Илүүдэл жингүй эртэч Монгол" аяны хүрээнд зохион байгуулсан 3 удаагийн спорт өдөрлөгт 26 байгууллагын 2025 иргэн, Үндэсний спортын их наадмын хүрээнд Шагайн харваа, Сурын харваа 2 арга хэмжээнд 260 иргэн, "Хамтдаа алхаад эрүүлж" алхалтыг өвлийн улиралд 4 удаа зохион байгуулж 261 иргэн, нийт 9 арга хэмжээнд 2546 иргэнийг хамруулсан.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.1.2 Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	29	Дүүргийн Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг ААН-үүдийн дунд жил бүр зохион байгуулна.	2021-2024	НБХ	Дүүргийн төсөв	90.0	Тэмцээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 860 албан хаагчид хамрагдсан.	Спортын арга хэмжээнд дүүргийн төр, хувийн аж ахуй нэгж байгууллагын 800-аас доошгүй албан хаагчийг хамруулна.	20.0		2023 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан.	0%
2.1.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор фитнес болон спорт клубуудыг бодлогоор дэмжиж, иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	30	Фитнес болон спорт клубуудтай хамтран иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	2021-2024	НБХ, БТСХ	Дүүргийн төсөв	-	3 клубтай хамтран ажилласан.	1-2 төрлийн сайн дурын клуб байгуулсан байна.	-		2021 онд карате 1, таеквондогийн 1, боксын 2, чөлөөт бөхийн 1, жизуцугийн 1, нийт 6 клуб үйл ажиллагаа явуулж байсан бол 2022 онд шинээр жүдогийн 3, шатрын 1, таеквондогийн 1, фитнесийн 2 нийт 7 спорт клуб шинээр нээгдэн дүүргийн хэмжээнд спортын 13 клуб үйл ажиллагаа явуулж 887 иргэн спортоор хичээллэж байна.	100%
2.1.4 Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.	31	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.	2021-2024	НБХ, БТСХ, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	250.0	Спортын 10 төрлөөр шигшээ баг байгуулж спортын үйл ажиллагааг нь дэмжсэн.	Спортын 12-аас доошгүй төрлийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжсэн байна.	60.0		2021 онд дүүргийн Засаг даргын дэргэд өсвөрийн хөлбөмбөг, сагс, волейбол, чөлөөт бөх, жүдо, тэшүүр, ширээний тэннис, даам, софт тэннис, крикетийн шигшээ баг хичээллэж байсан бол 2022 онд хоккей, боксын спортын баг шинээр байгуулагдаж спортын 12 төрлөөр нийт 376 тамирчин бэлтгэл сургуулилтаа хийж байна.	100%
2.1.4 Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна.	32	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг Олон улсын урагдан тэмцээнд бэлтгэж оролцуулна.	2021-2024	НБХ, БТСХ	Дүүргийн төсөв	50.0	-	-	-		Засаг даргын дэргэдэх Өсвөр үе, залуучуудын шигшээ багаас олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах 7 тэмцээнд 29 тамирчин оролцож алтан медаль-10, мөнгөн медаль-5, хүрэл медаль-4 нийт 19 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. Үүнд: Дэлхийн аварга шалгаруулах 3 тэмцээнд (жудо, самбо, даам) 7 тамирчин оролцож, алтан медаль 5, мөнгөн медаль 2 хүрэл медаль 1, Олон улсын 2 тэмцээнд (Хүүхдийн наадам, чөлөөт бөхийн ОУ тэмцээн) 19 тамирчин оролцож, мөнгөн медаль 1, хүрэл медаль 2, Азийн аварга шалгаруулах 2 тэмцээнд (жудо, даам) 3 тамирчин оролцож, алтан медаль 5, мөнгөн медаль 2, хүрэл медаль 1 тус тус хүртсэн байна.	100%
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	33	Дүүргийн спорт цогцолборын барилга шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУХ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	10,200.0		Барилгын зураг ажил хийгдэж, Төсвийг Улс, дүүргийн төсөвт тусгуулна.	100.0		Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд "Спорт цогцолборын барилга"-ын зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр "Классик хаус" ХХК-тай гэрээ байгуулсан. Спорт цогцолборын барилга нь 586 үзэгчийн суудалтай. Сагсан бөмбөг, бокс, ресторан, фитнес, хурлын заал, ширээний теннис, ханын теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн тахимууд болон бусад дагалдах өрөө тасалгаануудтайгаар төлөвлөгдсөн. Загвар зураг батлагдсан. Ажлын зураг төсөв боловсруулагдаж байна.	50%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	34	Нийтийн эзэмшлийн талбай болон Ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд спорт талбай байгуулна	2021-2024	ТГУХ, ТНБХХУХ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	952.4	Нийт 8 спорт талбай байна.	2 байршилд спорт талбай байгуулсан байна.	300.0	НТХО 350.0 Хувийн хэвшил 80.0 ДТХО 400.0	Нийслэл, дүүргийн төсөв болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд 2022 онд 9 хорооны 18 байршилд спорт талбайг шинээр байгуулах болон засвар шинэчлэлт хийх ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 спорт талбай ашиглалтад орсон. Үүнд: 1, 2, 10, 12, 13, 17, 21 дүгээр хороодын 11 байршилд хэрэгжих 3x3 сагсан бөмбөгийн талбайн ажлаас 6 байршлын ажил ашиглалтад орж, 1, 10, 13, 21 хорооны 5 байршлын тохижилтын ажил он дамжин хэрэгжинэ. 1, 2, 12, 16, 24 дүгээр хороодын 5 байршилд хэрэгжих сагсан бөмбөгийн талбай /2 талт/-аас 1, 2, 12, 16 дугаар хорооны хийгдсэн 4 сагсан бөмбөгийн талбайн ажил дуусаж ашиглалтад хүлээн авсан. 24 дүгээр хороонд хийгдэх талбайн ажил он дамжин хэрэгжинэ. Хөлбөмбөгийн холбоотой хамтран 1, 4 дүгээр хорооны 34, 52 дугаар сургуулийн хөлбөмбөгийн талбайн ажил дуусаж ашиглалтад хүлээн авсан.	100%
2.2. Эрүүл мэнд												
2.2.1 Иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, зорилгоор "Цахим эмч" онлайн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	35	Иргэд өөрсдөө чихрийн шижин, цусны даралт зэрэг зонхилон тохиолдох өвчнийг өдөр тутам хянах, онлайн зөвлөгөө, үйлчилгээ авах цахим системийг нэвтрүүлнэ.	2022-2023	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Нийслэл, дүүргийн төсөв	60.0	-	Цахим эмчийн ахлын байрны судалгаа хийж, дүгнэлт гарган, үйлчилгээний цэс бүрдүүлнэ.	-	-	Эрүүл мэндийн яамны дуудлагын нэгдсэн "Цахим эмч 119" дугаартай холбох CallPro үйлчилгээг Эрүүл мэндийн төвийн 341003, Нэгдсэн эмнэлгийн 70049255 дугаарын утсанд холбон нарийн мэргэшсэн Цахим эмч ажлын байранд 4 эмч 24 цагаар "ковид, томуу, зөвлөгөө мэдээлэл" гэсэн 3 үндсэн үйлчилгээний цэстэй зөвлөмж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Нэгдсэн эмнэлэг: Алсын зайн зөвлөгөө өгөх "Телемедицин" төвийг 2022 оны 2 дугаар сард шинээр үйлчилгээнд нэвтрүүлж үйл ажиллагааг эхлүүлэн 1 ээлжинд 20 эмч, 24 цагаар ажиллахаар төлөвлөж, нийт 20 кабинетын зохион байгуулалтыг хийж, кабинет тус бүрийг дуу тусгаарлагчаар тусгаарлаж, компьютер дэлгэц, холбогдох тоног төхөөрөмжөөр хангасан. Программ хөгжүүлэлтийг нэвтрүүлж, 1500 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Эрүүл мэндийн төв: Жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 хорооны ӨЭМТ-үүдэд "Жирэмсэн эмэгтэй хяналт бүртгэл" цахим програм нэвтрүүлэн ажиллаж байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2667 жирэмсэн эх ханагдаж байгаагаас 575 ӨЭМТ, 2092 нь эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд байна.	100%
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	36	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	60.0	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37 хувь, Хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 78 хувь хамрагдсан.	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37,2 хувь, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 70 хувьд хүргэж эрт үед нь эмчилсэн байна.	15.0	-	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт эхний 11 сарын байдлаар: Артерийн даралтын эрт илрүүлэг үзлэгт 118527 хүн хамрагдахаас 97861 буюу 82.5%, Чихрийн шижин хэв шинж -2 эрт илрүүлэг үзлэгт 118527 хүн хамрагдахаас 86821 буюу 73.2%, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 14,450 эмэгтэй хамрагдахаас 5,501 буюу 38%, Хөхний хавдрын илрүүлэг үзлэгт 60,436 эмэгтэй хамрагдахаас 42,891 буюу 71% тус тус хамрагдсан байна.	100%
	37	БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	ХДХВ/ДОХ/БЗДХ-ын идэвхтэй эрт илрүүлэг 5960, гепатитын тохиолдлын түвшин-0.8.	Халдварт өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 5500 иргэнийг хамруулж, эрт үед нь эмчилсэн байна.	-	-	2022 оны 10 сарын байдлаар ХДХВ/ДОХ/БЗДХ-ын кабинетын үзлэгт 9498 иргэн хамрагдсан нь өмнөх оны суурь түвшингээс 38%-иар илүү байгаа бөгөөд 101 өвчлөл бүртгэгдсэнийг 100% эмчилсэн.	100%
38	Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор сүрьеэгийн төвийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоог нэмэгдүүлнэ.	Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор сүрьеэгийн төвийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Дүүргийн төсөв	-	Сүрьеэгийн шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.9 байна.	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.7-д хүргэнэ.	-	-	Сүрьеэгийн эрт илрүүлгийг хувийг нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, орон гэргүй болон эрсдэлт бүлгийн 200 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Дүүргийн хэмжээнд 141 шинэ сүрьеэ бүртгэгдэж, эмчилгээнд хамрагдаж, тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 7.2 промилль байна. Сүрьеэгийн эрт илрүүлэг 23%-тай байгаа нь өмнөх оныхоос 3 хувиар нэмэгдлээ.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	39	Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	Тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлын хамралт 96.7 хувь.	Товлолт дархлаажуулалтын хамралтыг 98.0 хувьд хүргэсэн байна. ковид-19 халдварын эсрэг вакцины хамрагдалтыг нэмэгдүүлэх.	-	-	2022 оны эхний 10 сарын байдлаар товлотт вакцины бүрэн тунгийн хамралт 95%-тай байна. Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын 11 цэгийг ажиллуулан 2022 онд 1-р тунд 761, 2-р тунд 991, 3-р тунд 10136, 4-р тунд 11083, 5-р тунд 115 иргэнийг хамруулж өссөн дүнгээр 1-р тунд 153,188,761, 2-р тунд 160,145,991, 3-р тунд 77,538, 4-р тунд 11,214, 5-р тунд 158 иргэнд үйлчилсэн.	100%
2.2.3 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	40	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	2022-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Нийслэлийн төсөв	40.0	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинетгүй байна.	Кабинетийг тохижуулна.	20.0		Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулахаар холбогдох байгууллагуудад мэргэжил арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллах 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 193, 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 200 дугаар албан бичгийг Нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. "Эрэгтэйчүүдийн кабинет"-ыг байгуулахтай холбогдуулан 1 эмч, 1 сувиллагч нарыг сургалтад хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган ажиллаж байна. 2023 оны хөрөнгө оруулалтад эрчүүдийн кабинетын 13.5, 6.9 м2 талбай бүхий 2 өрөөний засварын ажлын санал хүргүүлсэн.	30%
2.2.4. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.	41	Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	40.0	Жирэмсэн эмэгтэйчүүдийн 89.5 хувь нь жирэмсний эхний 3 сард хяналтад хамрагдсан.	Жирэмсний эхний 3 сарын хяналтыг 90,5 хувьд хүргэнэ.	10.0		2022 оноос жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 нь хорооны ӨЭМТ-үүдэд "Жирэмсэн эмэгтэй хяналт бүртгэл" цахим програм нэвтрүүлэн ажиллаж байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2667 жирэмсэн эх хянагдаж байгаагаас 575 ӨЭМТ, 2092 нь эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтанд байна. 11 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд жирэмсний эрт хяналтын хувь 92.5% байна.	100%
	42	Хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэлийн төсөв	40.0	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.2 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1.0 байна.	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.4 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.99 байна.	10.0		2022 оны 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлдээр нярай гэнэт эндэх 3, зүрхний төрөлхийн гажиг-3, нярайн амьсгалын гачаал 3, бүтэлт 3, нярайн хахах хам шинж 2, үжил 3, нярайн тархины ишемийн шалтгаант энцефалопати 3, уушигны хатгаа, олон эрхтний гажиг, нярайн уушигны ателектаз, перинаталь үеийн өюөрмөц халдвар, нярайн тархины хямрал, цитомегаловирус халдвар, сүрьеэгийн менингит, боглөрөлт гидроцефали тус бүр 1, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7, нийт 35 тохиолдол бүртгэгдсэн. 0-1 насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 2 тохиолдлоор нэмэгдэж 7.6 промилль буюу хотын дундаж /10.3 промилль/-аас 2.5 промиллоор бага, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 4 тохиолдлоор нэмэгдэж 1.7 промилль буюу хотын дундаж /1.9 промилль/-аас 0.2 промиллоор бага байна.	0%
2.2.5. "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулна.	43	СӨБ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт, үзлэг зохион байгуулна.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Дүүргийн төсөв	12.0	Үзлэгт 18628 хүүхэд, 189 багшийг сургалтад хамруулсан.	2000 хүүхэд, 2 үзлэг, 2 сургалт.	3.0		"Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд амны хөндийн амбулаторын үзлэгээр Эрүүл мэндийн төвд 2324, Нэгдсэн эмнэлэгт 2934 нийт 5258 хүүхэд хамрагдсан нь өмнөх жилээс 2333 хүүхдээр, нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээ хийлгэсэн. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийн 6 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж нийт 15085 хүүхэд хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. Нийт 20,343 хүүхэд үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө мэдээлэл өгснөөс эмчилгээ хийлгэж эрүүлжсэн 8% /2021 онд 7.2%/-аас байна. Амбулатороор эмчилгээ хийлгэж байгаа 954 хүүхэд видео болон биечлэн муляж /шүдний хиймэл загвар/ дээрх сургалтыг хийж амны хөндийн эрүүл ахуйн гарын авлага тараалаа.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.2.6. Үйлчилгээний жишигт нийцсэн Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг тодорхой бүсүүдэд барьж байгуулна.	44	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	2021-2023	ТГУХ, ГЗБА	Улс, нийслэл, дүүргийн төсөв,	8.200.0	5 өрхийн эрүүл мэндийн төв түрээсийн байранд үйл ажиллагааг явуулж байна.	3 ӨЭМТ-ийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.	4,100.0	УТХО 1,237.9 ДТХО 3,368.2	Хан-Уул дүүргийн хэмжээнд үйлчилгээний жишигт нийцсэн өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих 6 төсөл арга хэмжээ хэрэгжихээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил дуусаж улсын комисс хүлээн авах шатанд; -8, 16 дугаар хороонд 2022-2023 онд он дамжин хэрэгжих өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гүйцэтгэгч шалгарч, зураг төсөв батлагдан барилгын суурийн ажил хийгдсэн ажлын явц 20%; Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 21 дүгээр хорооны хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил дуусч, дотор заслын ажил хийгдэж байна. Улсын комисс ажиллуулахаар бэлтгэж байна. -15 дугаар хороонд шинээр баригдах хороо өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв батлагдсан. Ажлын явц 10%; -19 дүгээр хороонд өрхийн эмнэлгийн барилгын зориулалтаар орон сууцны 1 давхрын 3 өрөө байр худалдан авч, эмнэлгийн стандартад нийцүүлэн засвар тохижилтыг хийж ашиглалтад оруулсан.	100%
2.2.7. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.	45	Жишиг загвараар нэгдсэн эмнэлэг байгуулах ажлыг хамтран зохион байгуулна.	2022-2024	ТГУХ, ХУДНЭ	АХБ-ны зээл тусламж	60,000.0	-	Барилгын ажил эхэлсэн байна.	10,000.0	ДТХО 165.0	Мэргэжлийн хяналтын газрын барилга төлөв байдлын тухай дүгнэлт, үнэлгээний тайлан, өмч хамгаалах зөвлөлийн акт, нэгдсэн эмнэлгийн гадна барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбайн буулгалтын ажлын төсөв тус тус батлагдсан. Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн зүгээс нэгдсэн эмнэлэгийн төсөл хэрэгжих газар дээрх хуучин барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээний буулгалтын ажлын төндөрийг зарлаж гүйцэтгэгчээр "Юу зэт эрдэнэ" ХХК шалгарч Нэгдсэн эмнэлгийн хуучин 6 объект буулгахаас 4 объектийг буулгасан. Жишиг эмнэлгийн барилгын ажлыг 2023 оны хавар эхлүүлэхээр төлөвлөж байгаатай холбоотойгоор үлдсэн 2 объектийг шинэ барилгын гадна шугам сүлжээний ажил хийгдэх явцад цуулгах шаардлагатай болсон тул 2023 онд буулгахаар болсон. Ажлын явц 70%.	70%
	46	"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Дүүргийн төсөв	75.0	-	Хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	-	Дүүргийн төсөв 198.9	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 зорилтын 12 төсөл арга хэмжээнээс 10 арга хэмжээг бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээ хэрэгжих шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 84 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2022 онд "Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах болон нийтийн биеийн тамир, спортыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулах" зорилтын хүрээнд "Сонголын бэрхшээлтэй иргэдийн 3x3 сагсан бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдад дэмжлэг үзүүлэх" төсөл /0.99 сая/, "Эмч, эмнэлгийн ажилтны ур чадварыг дээшлүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдыг хэвийн ажиллах нөхцөл бололцоогоор хангахад дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд "Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эмч нарын амралтын өрөөний тохижилт" /16.7 сая/ төслийг тус тус хэрэгжүүлсэн.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.2.8. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын үр чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зорилгоор “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	47	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, ажилтнуудын мэргэжил, үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв,	80.0	Гадаад сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо 13 байна.	Үндсэн мэргэшлийн сургалтад 10-20 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан байна.	20.0		Дүүргийн хэмжээнд нийт 18 эмч, эмнэлгийн ажилтан үндсэн мэргэшлийн сургалтанд, 86 эмч, эмнэлгийн ажилтан туршлага солилцох арга хэмжээнд хамрагдсан байна. Үүнд: Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, ӨГМТ-үүдийн төрөлжсөн нарийн мэргэшлийн сургалтад 8, магистрын хөтөлбөрт 3, сургагч багшаар 3 эмч, ажилтан бэлтгэгдсэн. Итали, Вьетнам улсад тус бүр 1, ОХУ-д 2 сувилагч мэргэжил дээшлүүлж байна. Эрүүл мэндийн төвийн 45 эмч, эмнэлэгийн ажилчид ОХУ-д, Нэгдсэн эмнэлгийн 41 эмч, эмнэлэгийн ажилчид Турк улсад туршлага солилцох арга хэмжээнд хамрагдсан байна.	100%
	48	Дүүргийн эрүүл мэндийн төсөвт байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТГУХ, НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	1,095.0	2021 оны төсөвт тоног, төхөөрөмжөөр хангахаар төсөв тусгагдсан.	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	235.0	НТХО 404.2	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлэгт 397 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн эмчилгээний тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн төвд 7.2 сая төгрөгийн төсөв бүхий ЭХО аппарат, сүрьеэгийн Gene Expert аппарат тус тус хүлээлгэн өгсөн.	100%
	49	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн байгуулах ажлыг зохион байгуулна	2021-2023	НБХ, ЭМТ, ХУДНЭ	Улс, нийслэлийн төсөв	1,050.0	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо-0.	Нийгмийн эрүүл мэндийн байгуулах санхүүгийн үүсвэрийг Нийслэлийн төсөвт тусгуулах.	-	УТХО 465.0	Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн эрүүл мэндийн төвд “Эрүүл мэндийн дэмжих төв”-ийг байгуулан нийт 15, нарийн мэргэжлийн эмч-5, сувилагч-4, Цахим бүртгэлийн ажилтан -2, ИТ инженер- 1, бусад албан хаагч-3 гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус төв нь 2022 оны 5 дугаар сарын 01-нээс эхлэн урьдчилан, сэргийлэх эрт илрүүлийн арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд 2022 оны эхний 10 сарын байдлаар 18-30 насны эрүүл мэндийн багцад 10508 иргэн, 0-5 насны 7559 хүүхэд, 6-17 насны 8956 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн засварын ажлын гүйцэтгэгчээр “ТИ ЭЙЧ ЭН” ХХК шалгарч, Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн хэсгийн нэгдүгээр давхарын баруун жигүүрт буулгалтын ажил, цахилгааны ажил, ариутгалыг 4 өрөө, лабораторийн 5 өрөөний их засвараас гадна дулааны магистрал шугамыг солих засвар хийж байна.	100%
2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор “Харшилгүй эрүүл дүүрэг” аян жил бүр зохион байгуулна.	50	“Харшилгүй эрүүл дүүрэг” аян жил бүр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангана.	2021-2024	НБХ, ТНБХХУХ	Дүүргийн төсөв	18.0	2 удаагийн сургалт өдөрлөг зохион байгуулж, 3878 иргэнийг хамруулсан.	Сургалтыг зохион байгуулж, 3000-аас доошгүй иргэнийг хамруулна.	5.0		Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөл, түнний хүндэрлийг бууруулах зөвлөлтөөг 31 удаагийн сургалтаар 4,972 иргэн, урьдчилсан сэргийлэх үзлэг 2,584 иргэн, зөвлөмж гарын авлагыг 1823 иргэнд өгсөн. ХУЭМТ болон ӨГМТ-ийн хуудсуудаар харшлаас сэргийлэх зөвлөмжийг 3,584 хүнд түгээж ажилласан.	100%
	51	Харшлын өвчин үүсгэгч шарилж, газрын хөл ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	2021-2024	ТНБХХУХ	Дүүргийн төсөв	12.0	692175 м2 талбайн шарилж хог ургамлыг устгаж цэвэрлэсэн.	“Шарилжгүй эрүүл дүүрэг аян”-г зохион байгуулж 70,000-аас доошгүй м2 талбайн шарилж хог ургамлыг устгасан байна.	3.0	ДТХО 9.6	“Шарилжгүй Улаанбаатар” аяныг дүүргийн хэмжээнд “Шарилжгүй эрүүл дүүрэг” уриан дор 2 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 328,968 м.кв талбайгаас 105,9 тонн шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэж, хяналт тавьж ажиллаа.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг/)	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал												
2.3.1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.	52	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ОБХ, МХХ, ЭМТ, ХУДНЭ, ЦГ, ЦЗХ	Дүүргийн төсөв	800.0	Хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай нөөцийг бүрдүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2022 оны 1 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2022 оны 3 дугаар тушаалыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн Онцгой комиссын даргын 2022 оны "Дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг бүлгийн зохион байгуулалтад шилжүүлэх тухай" А/02 дугаар тушаалаар дүүргийн Шуурхай штабыг 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн эрүүл мэндийн төлөвлөлт, зохицуулалтын бүлгийн зохион байгуулалтад шилжүүлсэн. Коронавируст (Ковид-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг дамжуулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, халдварын нөхцөл байдалтай холбогдуулан хариу арга хэмжээ авах 14 заалт бүхий төлөвлөгөөг 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр дүүргийн Засаг даргын нэгдүгээр орлогч, Шуурхай штабын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан иргэдэд чиглэсэн олон нийтийн сүлжээнд мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг тарааж, ЕБС болон СӨБ-ын эмч нарт сургалт сурталчилгаа явуулж, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллаж, Ковид 19-ийн бэлэн байдлыг ханган 3-6 сарын нөөц бүрдүүлэн ажиллаж байна. "Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамжийн нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын дагуу нөөц бүрдүүлж burgetel.mohs.mn-д бүртгэлийг хөтлөж хэвшсэн. Эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийт 60 орчим сая төгрөгний нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Коронавируст халдварын өвчлөлийн түвшин буурч улбар шар түвшинд шилжсэнтэй холбогдуулан тандалт шуурхай хариу арга хэмжээний багийг бүлгийн зохион байгуулалтад шилжүүлэн 4 бүлэг 11 эмч мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсан. 7-р сараас халдварын тохиолдол ихэссэнтэй холбогдуулан Тандалт хариу арга хэмжээний багийн үйл ажиллагааг 24 цагт шилжүүлэн ажиллуулж, өвчлөлийн түвшин 9-р сараас ногоон түвшинд шилжсэн тул Тандалт шуурхай хариу арга хэмжээний үйл ажиллагааг 8, 16 цагт шилжүүлэн ковидын амбулаторийг ажлын өдрүүдэд 8:00-17:00 цаг хүртэл ажиллуулж байна.	100%
2.3.2 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, заавар, зөвлөмж өгөх замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	53	Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ХХҮХ, МХХ	-	-	Хүнсний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний 1600 аж ахуйн нэгж байгууллага халдвар хамгааллын дэглэм мөрдөн ажиллаж байна.	Худалдаа, үйлчилгээний 1600-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллана.	-	-	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ.	-
2.3.3 Гамшигийн үеийн бэлэн байдалтай холбоотой хүнсээр хангах албаны мэргэжлийн ангийн тоог нэмэгдүүлж, хүнсний хангамжийг тогтворжуулна.	54	Дүүргийн Хүнсээр хангах албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ХХҮХ	-	-	Хүнс нийлүүлэхээр ханган байгууллагатай гэрээ байгуулсан.	35-аас доошгүй аж ахуйн нэгжтэй болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээ байгуулж, шаардлагатай хүнсний нөөцийг бүрдүүлсэн байна.	-	-	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжинэ.	-
2.3.4 Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тохиромжтой байршуулах худалдан борлуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	55	Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд	ХХҮХ, ЖДҮТТ	-	-	2020 онд нөөцийн махны өргөтгөсөн худалдаа 2 удаа 5 байршилд зохион байгуулсан.	Иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн 2-оос доошгүй удаа худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	-	Дүүргийн төсөв 2.5	Хүн амын хаврын хэрэгцээний махны хүртээмж, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр нөөцийн махны жижиглэн худалдааг 48 хүнсний дэлгүүр, 12 сүлжээ дэлгүүрээр 135.6 тонн, өргөтгөсөн худалдааг давхардсан тоогоор 39 байршилд зохион байгуулж 323.5 тонн, нийт дүүргийн хэмжээнд 459.1 тонн нөөцийн мах худалдан борлуулагдсан байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн хувь	
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
2.4. Хотын соёл												
2.4.1 Бүх шатны боловсрол соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлэх	56	"Монгол үндэсний бахархлын өдөр" ийг тохиолдуулан "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулах	2021-2024	НБХ, СО, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	3.5	135 сурагчийг хамруулсан.	100 сурагч хамруулна.	1.0		Монгол Улсын иргэний үнэмлэх гардуулах "Иргэний андгай өргөх ёслол"-ыг 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж 85 сурагч, 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан "Иргэний андгай өргөх ёслол"-д 32 сурагч, нийт 117 сурагчдыг хамруулсан.	100%
	57	"Хотын соёл" цуврал контент, видео шторк бэлтгэж, цахим аяныг талуудтай хамтрах хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, ШАОНХА, СО, ГБХЗХХ, АБНТБТ	-	60.0	Сургалт, өдөрлөг нийт 9 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.	Цуврал контент, видео шторк 3-аас доошгүй нэмэгдүүлсэн байна.	15.0	Дүүргийн төсөв 4.2	Залуучуудад хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх хотын соёлтой иргэн байхад уриалах тэдний оролцоотойгоор соёлыг өсвөр үе залуучуудад хүргэх, үндэсний өв соёлоо хайрлан хамгаалдаг ёс зүйтэй иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор "Хотын соёл-Хан-Уул"-аас олон нийтийн соёлын арга хэмжээг 2 үе шаттайгаар 25 хороодын цацарлэгт хүрээнд зохион байгуулан нийт 3466 иргэдийг хамруулсан. "Хотын соёл" аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв коллежуудын 1045 оюутанд "Хотын соёл-Хорт зуршил" сургалт зохион байгуулж, "Хотын соёл-Хорт зуршил" сэдэвт илтгэлийн уралдааныг зарлаж 7 багийн 60 оюутан сурагчдыг хамруулав. Хотын соёл аяны хүрээнд 3 шторк, 16 постер хийж байгууллагын пэйж болон группт байршуулж, 8963 иргэнд хүрсэн.	100%
2.4.2 Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс үндэсний бахархал, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж хэвшүүлнэ.	58	Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд Богцон дахь соёлын өв сэдэвт олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.	2021-2024	АБНТБТ, НБХ	Дүүргийн төсөв	4.0	2 удаагийн үйл ажиллагаанд 100 хүнийг хамруулсан.	100-аас доошгүй хүнийг хамруулна.	1.0		Соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, хадгалж хамгаалах чиглэлээр "Дээлтэй монгол", "Нүүдэлчин Монгол" их наадам, Түүх соёлын хөшөө дурсгалын тооллого, "Соёлын бүтээлч сар" зэрэг улс, нийслэл, дүүргийн томоохон арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулан 2300 гаруй иргэнийг хамруулсан. Сурагчдын өвийн боловсролыг нэмэгдүүлэх, өв соёлоо мэдэх, түгээрээ бахархах, хайрлах хамгаалах, бусдадаа эв үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор "Өвийн жим" клубээс "Өв бидний бахархал" самбарын үзүүлэн, "Өв соёлоо танин мэдье" аялал зохион байгуулсан. "Дэлхийн өв ба ач холбогдол", "Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин", "Өвийн боловсрол" сургалтыг "Хангай" дээд сургууль, ШУТИС-ийн харьяа МСҮТ-ийн АБНТБТ-өвийн суралцагч, 5,7,12,13,14,15 дугаар хорооны хэсгийн ахлагч нар, нийт 165 иргэнд зохион байгуулсан	100%
	59	Дүүргийн хүүхэд, залуучуудыг үндэсний дуу, хөгжим, бүжгийн сургалтад хамруулна.	2021-2024	НБХ, СО	-	-	4 төрлийн сургалтад 100 хүнийг хамруулсан.	100-аас доошгүй хүнийг хамруулна.	-		Хан-Уул дүүргийн соёлын ордонд морин хуур, төгөлдөр хуур, бүжиг, ёочин, ятганы 5 дугуйланд 137 хүүхэд суралцаж байна.	100%
	60	Түүх, соёлын үл хөдлөх өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	2021-2022	НБХ, СО	Нийслэл, дүүргийн төсөв	200.0	Дүүрэгт сэргээн засварлах шаардлагатай 3 соёлын өв байна.	1 соёлын өвийг сэргээн засварласан байна.	50.0		Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 22 дугаар хорооны Их тэнгэрийн аманд байрлах хүрэл зэвсгийн үеийн хадны зосон зураг болон 13-р зууны үед холбогдох бөхэн зураг, Монгол, Хятад, Төвд бичээс бүхий Монголын түүх, соёлын үнэт өв газрыг сэргээн засварласан. Түүх, соёлын үл хөдлөх өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байгаа түүх соёлын, үл хөдлөх өвийн улсын тооллогод 44 соёлын биет өвийг хамруулж, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах эрсдэлт нөхцөлд байсан Хүннүгийн үед хамаарах 8 булш, хиргэсүүрийг хамгаалалтад авсан.	100%
61	Дүүргийн Соёлын ордны барилгыг шинээр барих ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2022-2024	ТГУХ, НБХ, СО	Улс, нийслэлийн төсөв	8,500.0	Хуучин барилгын ашиглалтын шаардлага хангахгүй гарсан.	Зураг төсөв боловсруулж, шаардагдах санхүүжилтыг улс төсөвт уламжилна.	-		Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд Хан-Уул дүүргийн Соёлын ордны хуучин барилгыг буулгаж шинээр барих саналыг дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06/161 дугаар албан ёсоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст уламжилсан.	100%	
БҮЛГИЙН ДУНДАЖ ХУВЬ											88.5%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үрдүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ												
3.1 Иргэн төвтэй үйлчилгээ												
3.1.1 Иргэдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалт бүхий хөгжлийн төвүүдийг нээн ажиллуулна.	62	Ахмад залуучуудын болон иргэдийн хөгжлийн төвийн барилгыг барьж байгуулах ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2023	ТГУХ, НБХ	Улс, нийслэлийн төсөв	2,100.0	4 хороонд ахмадын хөгжлийн төв ажиллуулж байна.	Иргэдийн хөгжлийн төвийн 1 барилга ашиглалтад орно.	800.0		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалттай Иргэдийн хөгжлийн болон Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 12 дугаар хорооны "Иргэдийн хөгжлийн төв"-ийн барилга усралтын ажил дуусаж, улсын комисс ажиллах шатанд, 5 дугаар хорооны Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын явц 50 хувь, 12 дугаар хорооны Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын явц 70 хувь, 16 дугаар хорооны Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй байна.	100%
3.1.2 Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хороодын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	63	"Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ"	2022-2023	ТЗУХ	Дүүргийн төсөв	30.0	-	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн байна.	20.0		2023 оноос нэвтрүүлэхээр төсвийн төсөлд санал өгсөн.	0%
	64	Хороодын хөгжил дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ	Дүүргийн төсөв	117.0	-	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувь.	-	Дүүргийн төсөв 112.2	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дэд хөтөлбөрийн 5 зорилтын 12 арга хэмжээнээс 10 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 1 арга хэмжээ хэрэгжих шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 85 хувийн гүйцэтгэлтэй байна.	90%
3.2 Ухаалаг төрийн үйлчилгээ												
3.2.1 Дүүргийн иргэд болон гадаадад амьдарч байгаа иргэдэд зориулж төрийн үйлчилгээг хялбаршуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мобайл аппликейшнийг хөгжүүлэн, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	65	Мобайл аппликейшнийг хэрэглэнд бүрэн нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ	2022-2024	ААӨХ, ОНХА	-	55.0	Мобайл аппликейшнийг хөгжүүлэлт хийгдсэн.	Шинээр сервер авч аппликейшин байршуулна. 3 үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна.	20.0		Шаардлагатай төсөв шийдвэрлэгдээгүй.	0%
3.2.2 Засаг захиргааны анхан шатны нэгж хорооноос иргэдэд хүргэж буй үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	66	Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	2021-2023	ТЗУХ, ААӨХ, УБХ	-	-	1 хороонд УБХ-ийн 4 төрлийн үйлчилгээ үзүүлдэг.	2-4 хороонд 5-7 төрлийн үйлчилгээ үзүүлнэ.	-		2022 онд 24 хороонд улсын бүртгэлийн 18 төрлийн лавлагаа, үйлчилгээг иргэдэд шинээр олгож эхэлсэн ба цахимаар иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн 39, лавлагаа 19, ад хөрөнгийн бүртгэлийн 9, лавлагаа 3 нэр төрөл нэмэгдсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр 2022 онд 25 нэр төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлснээр нийт 69 нэр төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжлээ. Мөн 24 хороонд МИОСК автомат машин байршуулснаар дээрх төрийн үйлчилгээний төдийгүй, бусад төрлийн нийт 115 нэр төрлийн татвар, төлбөр хураамжийн үйлчилгээг иргэд шуурхай авдаг болсон.	100%
3.2.3 Дүүргээс аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	67	Цахим бүртгэлийн системд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулна.	2021-2024	ХХҮХ	Нийслэлийн төсөв	-	"Хан-Уул эко дүүрэг" цахим системд 1100 иргэн, аж ахуйн нэгж.	Цахим санд нийт аж ахуйн нэгж байгууллагын 60-аас доошгүй хувийг хамруулна.	-		Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1675 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг egr.ulaanbaatar.mn цахим хаягын аж ахуйн нэгжийн бүртгэл цэсэнд бүртгэж, мэдээллийг нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.	90%
3.2.4 Захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бүс, иргэд олноор цуглардаг газруудад утасгүй интернетийн сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	68	Иргэд олноор цуглардаг бүсүүдэд утасгүй интернетийн сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2022-2024	ААӨХ, ТГУХ	Дүүргийн төсөв	75.0	2020 онд 4 байршилд утасгүй интернетийн сүлжээ суурилуулсан.	2 байршилд утасгүй интернетийн сүлжээ суурилуулна.	25.0		Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны гаднах бичил цэцэрлэгт хүрээлэн, 2 дугаар хорооны 7,8 дугаар байрны бичил цэцэрлэгт хүрээлэнд утасгүй интернетийн сүлжээ суурилуулсан. Мөн дүүргийн 21 дүгээр хорооны цэцэрлэгт хүрээлэн, Богдын музей, 1 дүгээр хорооны шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад судалгаа хийгдэж, нийт 3 байршилд утасгүй интернетийн сүлжээ суурилуулах байршил, тоног төхөөрөмжийн судалгаа хийгдсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үрдүгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
3.2.5 Дүүргийн худалдаа үйлчилгээний цэг салбарыг нэгдсэн цахим системд оруулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно.	69	Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хийх гэрээ, олгох батламжийн үйл ажиллагааг цахимжуулна.	2021-2022	ХХҮХ, ААӨХ	-	-	-	Цахимаар гэрээ батламж олгох үйл ажиллагаа 50%-д хүргэнэ.	-	-	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй хийх гэрээ, батламжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: 1. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд цахим бүртгэлийн системийг танилцуулах сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 5 удаа танхимаар зохион байгуулж 248, цахимаар 4 удаагийн сургалт зохион байгуулж нийт 566 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд бүртгүүлэх гарын авлага бэлтгэж нийт давхардсан тоогоор 1884 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 2. Цахим бүртгэлийн системд 2022 онд 1018 иргэн, аж ахуйн нэгж гэрээ, батламж олгох хүсэлт илгэсэнээс шаардлага хангасан 519 аж ахуйн нэгж буюу 50.9%-д цг код бүхий бүртгэлийн хуудсыг олгосон.	100%
3.3. Мэргэшсэн тогтвортой төрийн алба												
3.3.1 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна.	70	Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, дотоод болон гадаадын богино, дунд хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлнэ	2021-2024	ТЗУХ	Дүүргийн төсөв	200.0	2020 онд 49 албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.	20 албан хаагчийг сургалтад хамруулж мэргэжил, ур чадварыг дээшлүүлнэ.	50.0	Дүүргийн төсөв 2.3	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 7 жил 90 хувийн хэрэгжилттэй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Удирдлагын академийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 4, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан бөгөөд Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуульд магистрын зэрэг горилсон гарагийн сургалтад суралцаж буй 4 албан хаагчид хичээлтэй гарат цалинтай чөлөө олгон албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Нийслэлийн Хүний нөөцийн Хөгжлийн төвөөс зохион байгуулсан 20 төрлийн сургалтад давхардсан тоогоор 96 албан хаагч, "АЗ" гэрчилгээ олгох сургалтад 11 албан хаагчийг тус тус хамруулсан. Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" цахим сургалтад албан хаагчдыг тухай бүр идэвхтэй хамруулсан. Тайлант хугацаанд нийт 25 төрлийн сургалтад 122, цахимаар болон цаг үеийн шинжтэй бусад сургалтуудад 300 гаруй албан хаагчийг хамруулсан.	100%
	71	Төрийн албаны тухай хууль болон холбогдон гарсан журмын хүрээнд бүтэц орон тоог шинэчилэн баталж, ажлын уялдаа холбоог сайжруулна	2021-2022	ТЗУХ	-	-	Бүтэц орон тоо шинэчлэн батлаагүй.	Шинэ бүтэц орон тооны дагуу ажлын уялдаа холбоог сайжруулах ажил хэрэгжүүлсэн байна.	-	-	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/129, А/527 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/18, А/87 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг тус тус баталж хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
3.3.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана.	72	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж, дүүргийн цахим хуудас, болон хороодоор дамжуулан авилгаас ангид байх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ	Дүүргийн төсөв	10.0	2020 онд 2 удаагийн сургалтад нийт 49 албан хаагчдыг хамруулж, 3 контент байршуулсан.	2 удаагийн сургалт зохион байгуулж, 2 контент байршуулна.	3.0	Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2 сургалт, 1 судалгаанд нийт 110 албан хаагчийг хамруулсан.Үүнд: Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны дарга нар, орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд нийт 31 албан тушаалтныг Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд оролцуулсан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх нь" сэдэвт цахим сургалтад 45, танхимын сургалтад 4 албан хаагчийг тус тус хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Шудрага байдлын үнэлгээ 2022" судалгаанд байгууллагын 30 албан хаагч болон Засаг даргын Тамгын газартай хамтран ажилладаг 20 байгууллага, албан хаагчаас шинжээчийн судалгаа авч холбогдох байгууллагад хүргүүлсэн.	50%	
3.3.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэлээр, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	73	Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг харгалзан, холбогдох журмын дагуу үнэлгээг тооцож, цахим хуудаст ил тод мэдээлнэ.	2021-2024	ТЗУХ	-	-	Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	Ёс зүйн зөрчилгүй хамт олонг бий болгоно.	-	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажил 85 хувийн хэрэгжилттэй. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэх талаар нийт албан хаагчдад анхааруулж, хяналт тавьсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 7 өргөдөл ирүүлснээс 5 албан хаагчтай холбоотой асуудлыг байгууллагын Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор дээрх 5 албан хаагчид сануулах хариуцлага хүлээлгэсэн. Хорооны 1 албан хаагчид 1 сарын цалингийн 20 хувь, 1 хэсгийн ахлагчид 1 сарын цалингийн урамшууллын 20 хувиар буулуулах сахилгын шийтгэл тус тус ногдуулсан байна.	100%	
3.3.4 Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороог ажлын албатай болгон санхүүгийн хувьд бэхжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	74	Хороодыг ажлын албатай болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2022-2023	ТЗУХ, СТСХ	-	-	21 хорооны өдөр тутмын үйл ажиллагаанд зориулсан төсөвтэй болсон байна.	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 68 дугаар тогтоолоор дүүргийн зарим хорооны нутаг дэвсгэр, хилийн заагийг шинэчлэн, 5 хороог шинээр байгуулж, нийт 24 хороо үйл ажиллагаа явуулж байна. Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар 25 хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай хангамжийн зардал болох сар тутмын 500,000.00 төгрөг буюу нийт хороодын жилийн зардалд 156,931,200 төгрөгийн төсөв батлагдаж, зардлыг хороодод тогтмол олгож байна.	100%	
3.4 Иргэдийн аюулгүй, амар тайван байдал												
3.4.1 Авто замын шаардлагатай бус, гэр хорооллын гудамж талбай болон орон сууцны хорооллуудын эмзэг бүсийг хяналтын камерын системд бүрэн хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	75	Хороодын нутаг дэвсгэрийг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2022	ТГУХ, ТНБХХУ Х, ЦГ, НУА ОНӨААТ ҮГ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	2,000.0	Дүүргийн нутаг дэвсгэрт 1435 ширхэг камер байна.	Нийтийн эзэмшлийн талбай болон ААНБ-уудын орчинд 100-аас доошгүй камер суурилуулсан байна.	227.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 522 ширхэг камер суурилууллахаар төлөвлөсөн. Үүнд: 1. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн тусгай зориулалтын 10 ширхэг камержуулалт /12, 13, 14, 16, 21-р хороо/-ын ажлын гүйцэтгэгчээр "Сонголт нар" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 80 хувьтай. 2. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт /1-5, 9-11, 13-21-р хороодод 117 ширхэг/-ын ажлын гүйцэтгэгчээр "Арш технологи" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 90 хувьтай. 3. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт / 12, 13, 14-р хороодод 80 ширхэг/-ын ажлын гүйцэтгэгчээр "Бодь-Электроникс" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Зураг төсөл боловсруулагдах шатанд. Ажлын явц 10 хувьтай. 4. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт /1, 2, 3, 6, 7, 8, 17, 19-р хороодод 53 ширхэг/-ын ажлын гүйцэтгэгчээр "Инносольюшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Зураг төсөл боловсруулагдах шатанд. Ажлын явц 10 хувьтай.	100%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь	
								2022 он					
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)			
3.4.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	76	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021-2024	ХЭЗАХ, ЦГ	-	-	50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан.	50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан байна.	-	НТХО 265,4	"Сэрэмжлүүлье" арга хэмжээний хүрээнд 50 иргэнийг 6, 7 дугаар саруудад үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлд ажиллуулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаартай тогтоолын хүрээнд 25 олон нийтийн цагдаа, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 74 дүгээр тогтоолын хүрээнд 15 оюутан цагдаа тус тус ажилласан. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны А/48 дугаар тогтоолоор "Оюутан эргүүл ажиллуулах журам" батлуулж журмын хэрэгжилтийг хангах зорилгоор "Хөдөө аж ахуйн их сургууль"-ийн 1500, бусад сургуулийн 2300 нийт 3800 орчим оюутнуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр 650 оюутан эргүүл ажилласан.		100%
3.4.3 Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэрэгжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	77	Согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг аюулын талаар мэдлэг олгох хичээлийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж сурталчлах	2021-2024	ХЭЗАХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	Дүүргийн төсөв	3.2	5 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж нийт 348 сурагч хамруулсан.	8 удаагийн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж нийт 800 сурагч хамруулсан байна.	0.8		Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх 16 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж 1065 сурагч, 1625 иргэдийг оролцуулсан. Үүнд: "Эрх зүйн сургалтны нэгдсэн төлөвлөгөөний" дагуу ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс, Прокурорын газар, Албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх тухай, Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай гэсэн сэдвүүдийн хүрээнд 7 удаагийн сургалт зохион байгуулж нийт 915 ахлах ангийн сурагчдыг; "Хар тамхигүй дүүрэг" тусгай арга хэмжээнд төрийн болон төрийн бус 120 байгууллагын 400 ажилтан, алба хаагч, 1145 эцэг эхчүүд, нийт 1545 иргэдийг; Электрон тамхины хор нөлөөллийг таниулах, урьчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын 34, 41, 52, 18, 7, 89, 75 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад 7 удаа зохион байгуулж 150 гаруй сурагчдыг тус тус хамруулсан. Өсвөр насны хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн анхан шатны мэдлэг олгох, хорт зуршлаас татгалзах, сэтгэл зүйн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл олгох "YOUTH BOX" явуулын үйлчилгээг Ажилчны алдарын талбайд зохион байгуулж 80 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.		100%
	78	Цахим сүлжээ ашиглан хар тамхи, мансууруулах бодисоос хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилго бүхий оюутан, залуусын дунд мэдээ мэдээлэл, сурталчилгаа явуулна.	2021-2024	ХЭЗАХ, НБХ, ЦГ, ГБХЗХХ	-	-		Цахим сүлжээнд мэдээ мэдээллийг тогтмол оруулна.	-		Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 телевиз, радио, сайтаар 45 мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд олон нийтэд хүргэж ажилласан. Үүнд: Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн "Амрыг эрье", "Ярилцах цаг", "Mongol HD" оргил цаг, "ТВ5" цаг мэдээллийн хөтөлбөр зэрэг 9 телевизийн нэвтрүүлэгт 23 удаа, "Дэлхийн Монгол Радио 88.3", "Гэр бүлийн радио 88.8" 2 радиогоор 6 удаа, "ТУГ.мн", "Gogo", "Арслан.мн", "News.мн", "Товч.мн" зэрэг 5 сайтад 16 мэдээ тус тус байршуулсан. "Мансууруулах эм, сэтгэцэд сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх" сэдвээр 21 удаагийн сургалт зохион байгуулсан. Дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн пэйж хуудсаар 15 удаагийн постер мэдээлэл, khanuul.child.gov.mn сайтад 12 постер бэлтгэж мэдээллийг түгээж 1238 хүнд хүргэсэн.		100%
3.4.4 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах "Хүүхэд хамгаалагч" төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэлийг бууруулна.	79	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах "Хүүхэд хамгаалагч" төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2021-2024	ХЭЗАХ, НБХ, ГБХЗХХ, ЦГ, БХ	Улсын төсөв	64.8	Хүүхэд хамгаалагчаар 21 хүн ажилласан.	Хүүхэд хамгаалагчаар 21 хүн ажилласан байна.	16.2	ХНХЯ 73,0	Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалагч" төслийн хүрээнд хүүхэд хамгаалагчаар 29 иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Хүүхэд хамгаалагчид хүүхдийг гэмт хэрэг, эрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 526 хүүхэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.		100%
БҮЛГИЙН ДУНДАЖ ХУВЬ												87%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
ДӨРӨВ. НИИГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ												
4.1. Боловсрол												
4.1.1. Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээнд 20-иос доошгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	80	Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, НБХ, БХ	Улс, нийслэл, дүүргийн төсөв	79,372.0	2020 оны байдлаар нийт 1840 суудал, 6 цэцэрлэг, 5810 ор тус тус байна.	3 сургууль буюу 1840 суудал, 6 цэцэрлэг буюу 1000 ороор нэмэгдэнэ.	19,603.0	УТХО 17,848.5 НТХО 7,800.0 ДТХО 6,235.8	Хан-Уул дүүргийн хэмжээнд боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтаар 1, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 сургуулийн барилга, бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга-1, цэцэрлэгийн барилга-11 буюу нийт 18 төсөл арга хэмжээ; Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилга-3, бага сургууль, цэцэрлэгийн барилга-5, цэцэрлэгийн барилга-3 нийт 11 төсөл арга хэмжээ; Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилга-3, нийт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 33 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. -Дүүргийн хэмжээнд 2022 онд 8, 21 дүгээр хороонд 1280 суудал бүхий 2 сургуулийн барилга 21, 23 дугаар хороонд 580 орны багтаамжтай 2 цэцэрлэгийн барилга нийт 4 барилга ашиглалтад орсон. -13 дугаар хороонд 180 суудал, 100 ортой 1 бага сургууль, цэцэрлэгийн барилгын цогцолбор, 3, 4, 9 дүгээр хороонд хэрэгжиж буй нийт 680 орны хүчин чадалтай 3 цэцэрлэгийн барилгын угсралтын ажил тус тус дуусаж улсын комисст хүлээлгэн өгөх баптгал ажил хангагдаж байна. -4, 12, 21 дүгээр хороонд хэрэгжиж буй нийт 2240 суудал бүхий 3 сургуулийн барилга, 5, 16 дугаар хороодод хэрэгжиж буй нийт 350 орны хүчин чадалтай 2 цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 50-95 хувь; -19 дүгээр хороонд хэрэгжиж буй 320 суудал бүхий 1 сургуулийн барилга, 1, 4, 10, 15, 19, 20 дугаар хороодод хэрэгжиж буй 1200 ор бүхий 6 цэцэрлэгийн барилга угсралтын ажил 10-49 хувь, -4, 12, 19, 21 дүгээр хороодод хэрэгжих 2880 суудал бүхий 4 сургууль, 9, 12, 14, 16 дугаар хороодод хэрэгжих 900 суудал, 500 ор бүхий 5 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга, 4/23, 24/, 8, 16, 18 дугаар хороодод хэрэгжих 920 ор бүхий 4 цэцэрлэгийн барилгын ажлын явц зураг төсвийн шатанд тус тус хэрэгжиж байна.	90%
4.1.2 Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	81	Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, БХ	Дүүргийн төсөв	105.0	Үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	-	Дүүргийн төсөв 14.0	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор "Багш" дэд хөтөлбөрт 3 зорилт, 14 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр батлагдсан. 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн дэд хөтөлбөрийн 3 зорилт, 11 төсөл, арга хэмжээний 2022 оны хэрэгжилт 75 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд "Орчин анхдагч байх зарчимд суурилан сургалтанд дэвшилтэт технологийг нэмэгдүүлэх, эрүүл ахуй, орчны аюулгүй байдалд шаардагдах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд ерөнхий боловсролын 15 дугаар сургуульд 14.0 сая төгрөгийн санхүүжилтээр 5 зөврийн компьютер нийлүүлсэн.	70%
4.1.3. Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлж, богино эргэлтийн шуурхай автобус бий болгох үйлчилгээг нэвтрүүлнэ.	82	Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны тоог нэмэгдүүлнэ.	2021-2024	НБХ, БХ	Нийслэл, дүүргийн төсөв	-	Төрийн өмчийн сургуульд - 7 автобус	6 автобусаар нэмэгдүүлнэ.	-	Дүүргийн төсөв 8.4	2022-2023 оны хичээлийн жилд "Сургуулийн автобус" төслийн хүрээнд Нисэх-Яармаг-120 мянгат,Чиглэл: Буянт Ухаа-2- Яармаг-120 мянгат гэсэн 3 чиглэлд чиглэлд 7,10, 26, 156, 63, 18,15, 75, 52 сургуулийн 483 сурагчид үйлчлүүлж, сургуулийн нийгмийн ажилтнууд хариуцан ажиллаж байна. Мөн төрийн өмчийн ерөнхий боловсролын 156, 26, 10, 135, 10 дугаар сургууль, нийт 5 сургуульд 6 автобус хүүхэд тээвэрлэж байгаа бөгөөд 311 хүүхэд хамрагдаж байна. 161, 163-р сургуульд дүүргийн Засаг дарлын нөөц хөрөнгөөс санхүүжилт шийдвэрлэж түрээсээр 1 жижиг, 2 том автобусаар БУ-2 хорооллоос 89, 60, 118-р сургууль чиглэлд 2022 оны 11 сарын 21-ний өдрөөс 300 хүүхэд автобусаар үйлчлүүлж байна. Нийт 12 автобусаар 1094 хүүхэд үйлчлүүлж байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үрдүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.1.4 Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох, сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	83	Сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	2021-2024	НБХ, БХ	Нийслэл, дүүргийн төсөв	-	Судалгааны ажил хийгдсэн.	Скүүл Алерт төхөөрөмжийн RFID tag бүхий үнэмлэх эзэмших сурагчдын тоог өмнөх жилээс нэмэгдүүлэх.	-	НТХО 639.0	НЗДТГ-аас хэрэгжүүлсэн Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангах "Скүүл алерт" төслийн хүрээнд 2021 онд ерөнхий боловсролын нийт 17 сургуулийн 15050 хүүхэд хамрагдсан. 2022 онд 700 хүүхэд нэмэгдэж нийт 15750 бага ангийн сурагчдад ухаалаг үнэмлэхийг олгосон. Төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургууль, автобусны буудал, хүүхэд ихээр зорчдог гудамж талбайд 174 уншигч төхөөрөмжийг байрлуулсан байна. Тонго төхөөрөмж ашиглах цахим гарын авлагыг боловсруулж хүргүүлснээр эцэг эх асран хамгаалагч нар хяналт тавьж ажиллах боломжтой болсон.	100%
4.1.5 Тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.	84	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, ХБХ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2021-2024	НБХ, БХ	Дүүргийн төсөв	-	2 удаагийн сургалтад 200 захирал, эрхлэгчийг хамруулсан.	4 сургалтад 200 багшийг хамруулж 250 хүүхдийг хамруулна.	-	ГТ 15.0	"Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд, сургалтын орчин, хамтын ажиллагаа" сэдэвт сургалтад 125 удирдах ажилтан, "Тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн онол практик" сургалтад 180 багш," Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, ажиллах арга зүй" сургалтад 271, нийт 3 сургалтад 576 багш, удирдах ажилтан хамрагдсан. 2022-2023 оны хичээлийн жилд тус дүүргийн ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 510 сурагч хамрагдаж байна. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/, БШУЯ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах " төслийн хүрээнд 280 ширхэг гарын авлага, зөвлөмж, видео хичээлийг 48 сургуульд хүлээлгэн өгч, JICA ОУБ-аас ерөнхий боловсролын 26, 34, 75-р сургуулийн "Дэмжлэгийн баг"-т сургалтын хэрэглэгдэхүүн, сургуулийн 1, 2 дугаар давхрын хөнгил, ариун цэврийн өрөөг тохижуулж, 75 дугаар сургуулийн дотоод орчинд тактель замыг байрлуулсан. Албан бус Насан туршийн боловсролын төв тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэглэгдэхүүнтэй өрөөг ашиглалтад оруулсан. Тэгш суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 10, налуу замтай 38 сургууль байна.	100%
4.2. Нийгмийн халамж												
4.2.1 Зорилтот өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	85	Зорилтот өрхийн 15-34 насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн судалгааг гаргаж, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулна.	2021-2024	НБХ, ХөХҮХ	ХЭДС	16.8	179 иргэн .	180 иргэн.		4.2	Зорилтот өрхийн 15-34 насны 900 иргэнд сургалт зохион байгуулах эрх бүхий 4 байгууллагатай гэрээлэн хөдөлмөрт бэлтгэх сургалт, ажлын байрны дадлагын сургалтыг зохион байгуулсан.	100%
	86	Зорилтот өрхийн иргэдийг ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2021-2024	НБХ, ХөХҮХ	ХЭДС	20.0	57 иргэн ажлын байранд зуучилсан.	50-аас иргэн. доошгүй		5.0	"Ногоон ажлын байр хөтөлбөр"-ийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа хайс тохижуулах, сэргээн засварлах, хог хаягдлыг цэвэрлэх, байгаль орчныг хамгаалах тохижилт үйлчилгээ хийх түр ажлын байранд нийт 163 иргэнийг хамруулсан. Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хорих ангиас суллагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны , хөдөлмөрийн чадвартай иргэн, асрамжийн газраас гарсан иргэн зэрэг 566 иргэнийг ажлын байранд зуучлан, 33 иргэнийг ажилд зуучилсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үрдүгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	87	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн "Уулзалт өдөрлөг", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтсан арга хэмжээ зохион байгуулна.	2021-2024	ХөХҮХ	Дүүргийн төсөв	40.0	370 иргэн хамруулсан.	375-аас доошгүй иргэнийг хамруулсан байна	10.0	Дүүргийн төсөв 72.53	"Ээлтэй дүүрэг" аяны хүрээнд 4 арга хэмжээ зохион байгуулж 376 иргэдийг хамруулсан. Үүнд: -"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн уулзалт, өдөрлөг"-т хөгжлийн бэрхшээлтэй 200 хүүхэд. -Ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн 40 сурагчийн тоглосон "Хөөрхөн ертөнц" жүжиг, -Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран Сэтгэлийн аялгуу хандивын тоглолтод 36 иргэн, Цагаан таягтны өдөрлөгт 100 иргэн тус тус хамрагдсан. Дүүргийн тусгай болон пара бочи, суугаа волейболын аварга шалгаруулах болон Бүх ард түмний XV их наадамд нийт 350 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон. Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад дэмжлэг үзүүлсэн.	100%
	88	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийг байгуулна.	2021-2022	ТГУХ	Улсын төсөв	305.0	Төсөв батлагдсан.	Тусгай хэрэгцээт иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийг ашиглалтад оруулна.	100.0	УТХО 266.6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 дугаар хороонд байрлах хуучин халуун усны барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв болгон засварлаж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100%
4.2.3 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	89	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах төсөл хэрэгжүүлэх	2021-2024	ХөХҮХ	Нийслэлийн төсөв	152.0	Зорилтот бүлгийн 55 иргэн хамрагдсан.	Зорилтот бүлгийн 65 иргэнийг хамруулна.	38.0	ХөЭДС 62.0 Дүүргийн төсөв 50.4	"Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах" үйлчилгээнд 62 зорилтот иргэний 31 бүлгийн төсөлд санхүүгийн буцалтгүй дэмжлэг олгов. Дүүргийн Засаг даргын захирамжаар туслалцаа дэмжлэг зайлшгүй шаардлагатай 7 өрхөд, ЗДТГ-ын хамт олон Сайн үйлсийн аян өрнүүлж 1 өрхөд, нийт 8 өрхөд 5 ханатай гэр, 63 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Нийт 8 өрх, 125 иргэдэд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.	100%
4.2.4 Ахмадуудын хөгжлийг дэмжих, тэдний мэдлэг туршлагаа залуу үедээ хуваалцах боломжийг хангах үүднээс "Ахмадаа дээдэлъе" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	90	"Ахмадаа дээдэлъе" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, АХ	Дүүргийн төсөв	140.0	24 төсөл арга хэмжээг зохион байгуулсан.	Дэд хөтөлбөр 50% хэрэгжсэн байна.	-	ДТХО 198.9	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 зорилтын хүрээнд нийт 7 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжүүлж, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд "Ахмадуудыг эрүүл насжихад бэлтгэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх боломжаар хангах" зорилтын хүрээнд "Ахмад настны эрүүл мэндийн гарын авлага" төсөл, "Ахмад настны ойлголт хандлагыг төлөвшүүлж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах" зорилтын хүрээнд, "Цагаан сар", "Ахмадын баяр" арга хэмжээг тус тус хэрэгжүүлэн 7000 гаруй ахмад настанд хүрч ажилласан.	70%
	91	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулна	2021-2024	НБХ, ХөХҮХ, АХ	ХЭДС	79.8	17 ахмад.	Зөвлөх үйлчилгээнд 25 ахмад хамруулна.	21.0	Улсын төсөв /ХЭДС/ 51.8	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргаа, уул уурхай, хууль эрх зүй, хөдөлмөрийн харилцаа зэрэг 6 чиглэлээр 48 иргэнийг хамруулсан.	100%
4.2.5 Дүүргийн "Эко ахмадын сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулж, ахмадууд үйлчлүүлэх амралт, сувиллын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	92	"Эко ахмадын сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулна.	2021	ТГУХ, ТНБХХУ Х, Эко ахмадын сувилал ОНӨААТ ҮГ	Дүүргийн төсөв	1,334.0	Барилгын ажил 90%-тай хэрэгжиж байна.	-	-	-	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хорооны Тайны аманд хэрэгжүүлсэн "Эко ахмадын сувилал"-ын барилгын ажил бүрэн дуусаж улсын комисст хүлээлгэн өгсөн. Гадна цахилгаан хангамжийн ажлыг 2022 оны 11 сарын 03-ний өдөр дуусгаж ашиглалтад авсан.	100%

4.3. Хөдөлмөр эрхлэлт

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.3.1 "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.	93	Халамжийн нэгдсэн систем ehalamj.mn/-ийг хөгжүүлж, нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	ХөХҮХ	-	-	6 төрлийн үйлчилгээ нэвтрүүлсэн.	15 төрлийн үйлчилгээ.	-	Улсын төсөв 112	2022 онд халамжийн нэгдсэн систем ehalamj.mn сайтаар цахим үйлчилгээ үзүүлэх нийгмийн халамжийн 25 төрлийн үйлчилгээ нэмэгдэж, нийт 69 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж, тайлант хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд давхардсан тоогоор 156.679 иргэдэд үйлчилсэн байна.	100%
	94	Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	2021-2024	ХөХҮХ	Улсын төсөв	50.0	2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг байгуулсан.	2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг.	10.0	ХөХҮХ/ үйл ажиллагааны зардал/ 5.7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг сурталчлах, иргэдэд таниулах, төсөл хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхтэй уялдуулан хэлтсийн ажилтан болон хороодын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтуудыг 3 удаа зохион байгуулсан.	100%
4.3.2 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	95	Шилдэг "Старт-ап" 2 багийг сонгон шалгаруулах, Старт-ап залуучуудад ментор хийх	2021-2024	ХөХҮХ	Улсын төсөв	168.0	5 баг.	2 баг.	28.0	НТХО 20.0	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газраас зохион байгуулсан залуучуудын гарааны бизнес, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт дүүргийн 48 залуучуудыг бүртгэн сургалтанд хамруулснаас 2 иргэний төсөл шалгаран санхүүгийн буцалтгүй дэмжлэг авсан.	100%
	96	"Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" бүлгээр ажиллах чадвар олгох сургалт зохион байгуулж гэрчилгээ олгоно.	2021-2024	ХөХҮХ	Дүүргийн төсөв	-	2020 онд "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл", сургалтад 36 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан.	40-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна.	-	ХөЭДС 4.0	Сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах эрх бүхий 6 байгууллагатай гэрээ байгуулан аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалтад 100 иргэнийг хамруулсан.	100%
4.3.3 Цагийн ажлын байрыг дэмжиж нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	97	Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	2021-2024	ХөХҮХ	Улсын төсөв	4.5	100 оюутанг цагийн ажилд зуучилсан.	100-аас доошгүй оюутанг цагийн ажилд зуучилна.	1.0	ХөЭДС 2.0	ХҮД-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, цагдаагийн хэлтэстэй хамтран Хөдөө аж ахуйн их сургуулийн 292 оюутнуудыг цагийн ажлын байранд зуучилсан.	100%
4.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон ажлын байрыг дүүргийн ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах замаар нэмэгдүүлнэ.	98	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах	2021-2024	ХөХҮХ	Улсын төсөв	376.0	48 иргэнийг сургалтад хамруулж, 25 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100-аас доошгүй иргэнийг сургалтад хамруулж, 20 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	84.0	ХөЭДС 283.5	"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд хөгжлийн "Аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалт"-д хөгжлийн бэрхшээлтэй 138 иргэнийг хамруулж, 43 иргэний төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор нийтийг хамарсан болон мод тарих зэрэг түр ажлын байранд 65 иргэнийг хамруулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100%
4.3.5 Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бий болсон ажлын байрыг бүртгэж, иргэдийг ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	99	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх	2021-2024	НБХ, ХөХҮХ, ЖДҮДТ	Улсын төсөв	111.4	700 иргэнийг ажилд зуучилж, 2880 иргэнд зөвлөгөө.	720-оос доошгүй иргэнийг ажилд зуучилж, 2800 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.	27.8	ХөЭДС 1,256.0	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад шинээр бий болсон 500 ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д нэмж бүртгэн, 568 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. ХҮД-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, цагдаагийн хэлтэс ХААИС-ийн 292 оюутнуудыг цагийн ажлын байранд зуучилсан. Ажил хайгч 2000 гаруй иргэнийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр"-ийг танилцуулах арга хэмжээнд, 900 залуучуудыг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх сургалтад хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор нийтийг хамарсан болон мод тарих зэрэг түр ажлын байранд 65 иргэнийг хамруулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	90%
4.3.6 "Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	100	"Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн төсөв	48.0	2020 онд, 24 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг "Түрээсийн төлбөргүй" борлуулсан.	50-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	12.0	12.0	"Хан-Уулд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг дүүргийн 23 дугаар хороонд байрлах Фүүд сити худалдааны төвд оруулах саналтайгаар "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төсөл"-ийг боловсруулан дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 14 дүгээр хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд уг төслийн хэрэгжих хугацааг хойшлуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор хүн амын нягтаршил ихтэй, нийтийн эзэмшлийн зам талбайд ил задгай худалдааг тогтмол зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх шийдвэрийн хүрээнд 12 удаагийн үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд үндэсний үйлдвэрлэл эрхлэгч нийт 160 иргэн, аж ахуйн нэгжийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж 243.5 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд: 1. "Цагаан сар-2022" 2. "Их хотын хавар-2022" 3. "Амралтын өдрийн худалдаа" арга хэмжээ; 4. "Улаанбаатар марафон-2022" 5. "Дээлтэй Монгол Наадам-2022" 6. "Ээлтэй ЭКСПО-2022" 7. "Дэлхийн Жижиг дунд үйлдвэрийн өдөр"	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үрдүгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
											1. "Дэлхийн Жижиг дунд үйлдвэрлэл өдөр" 8. "Даншиг Наадам-Хүрээ цам 2022" 9. "Хичээлийн Шинэ жил 2022-2023" 10. "Их хотын хямдрал-2022" 11. "Намрын ногоон өдрүүд-2022" 12. "Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа"	
4.3.7 Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	101	Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.	2021-2024	ХХҮХ, ЖДҮДТ	Нийслэлийн төсөв	-	12 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн.	15-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	-		Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д 15 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар ханган, бүтээгдэхүүнээр нь үзэсгэлэн гарган олон нийтэд сурталчлан танилцуулж 7.0 сая төгрөгийн борлуулалтыг дэмжин ажилласан. Мөн ажилгүй болон хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эмэгтэйчүүдэд өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжоор хангах зорилгоор чадавхжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж 90 иргэнийг хамруулсан. Сургалтаар лаа, ванны бөмбөлөг, давсан урлал, гар урлалын сургалтыг зохион байгуулсан.	100%
4.4. Дүүргийн төсөв, санхүү												
4.4.1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ.	102	Орон нутгийн төсвөөс санхүүжих буй байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулсан эсэхэд хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангана.	2021-2024	СТСХ, ДАА	-	-	нийт 195 байгууллага шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ байршуулсан. 87.6%	Хуулийн хугацаанд 205 байгууллагын шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ байршуулсан байна. 88%	-		Хуулийн хугацаанд нийт 21 ерөнхий боловсролын сургууль, 30 цэцэрлэг, 24 орон нутгийн төсөвт байгууллага, 15 өрхийн эмнэлэг, 25 хувийн сургууль, 98 хувийн цэцэрлэг нийт 205 байгууллага https://shilendans.gov.mn/ сайтад байршуулах шаардлагатай 2782 мэдээллээс 2451 мэдээлэл байршуулан 88.10% гүйцэтгэлтэй байна.	100%
4.4.2 Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулна.	103	Цахим татвар төлөлт, төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээний талаар сургалт зохион байгуулж үйлчлүүлж байгаа татвар төлөгчийн тоог багасгах.	2021-2024	ТХ	Үйл ажиллагаа нь зардал Татварын хэлтэс	85.0	Төлбөрийн даалгавар үүсгэх цахим систем 100% цахим хэлбэрт шилжсэн боловч цахим хэрэглээний түвшин муу байна.	Цахимаар төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээг 50% д хүргэх.	21.3		Татварын алба нь 100 хувь цахим тайлангийн системд шилжиж 2022 онд 71 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж 6031 татвар төлөгчийг хамруулсан байна. 2022 онд төлөлт хийгдсэн 323304 төлбөрийн даалгавраас 233104 буюу 72.0 хувь нь цахимаар төлөгдсөн бол 90200 буюу 28.0 хувь нь банк болон төрийн сангаар хийгдсэн гүйлгээ байна.	100%
4.4.3 Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлэх, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	104	Дүүргийн төсвийн хөрөнгөөр бий болж буй хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	2021-2024	СТСХ, ААӨХ	-	-	Нийт 68 байгууллага хамрагдаж, тооллогын комисст ажлын тайлан ирүүлсэн.	Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажлуудад өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах, чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. 70 байгууллагад хөрөнгийн тооллого хийгдсэн байна.	-		Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хяналт тавин, төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллого хийх ажил зохион байгуулагдан 90 байгууллагад хөрөнгийн тооллого хийсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/218 дугаар захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллого хийх ажлын хэсэг томилсон. Захирамжийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/36 дугаар тушаалаар 2 дэд ажлын хэсэг байгуулан 9 орон нутгийн байгууллага, 8 ОНӨААТҮГ, 21 сургууль, 29 цэцэрлэг, 18 эрүүл мэндийн байгууллага, 6 улсын төсвийн байгууллага нийт 91 байгууллагад тооллого зохион байгуулж дүн нэгтгэл хийгдэж байна.	100%
4.4.4 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	105	Дотоодын давуу эрх тооцох боломжтой төсөл арга хэмжээнд тухай бүрт тусгаж ажиллах	2020-2024	ХААА	-	-	Дотоодын давуу эрх тооцох төсөл арга хэмжээ 50%-тай байна.	Нийт арга хэмжээний 60%-д дотоодын давуу эрх тооцохоор тусгасан байна.	-		Дүүргийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 149 төсөл арга хэмжээ зарлагдахаас 108 төсөл арга хэмжээнд буюу 72.5 хувь нь дотоодын давуу эрх тооцохоор тусгасан. Үүнээс 21 төсөл арга хэмжээнд дотоодын давуу эрх тооцож 71,400,000 төгрөгийг тоног төхөөрөмж дотооддоо үйлдвэрлэдэг аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5. Гэр бүл												
4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	106	Гэр бүл хүүхэд залуучуудад ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж, Шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна	2021-2024	НБХ, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	16.0	"Хүүхэд гэр бүлд ээлтэй" 5 байгууллагыг шалгаруулсан.	5 байгууллага, 5 гэр бүлийг шалгаруулан сурталчилна.	4.0	НТХО 6.76	2022 онд Онцлог гэр бүл шалгаруулах үйл ажиллагаанд 15 гэр бүлийн материал хүлээн авч, Нийслэлд "Оюунлаг гэр бүл"-ээр Н.Нямдоржийн гэр бүл, "Авьяаслаг гэр бүл"-ээр Д.Шинацогийн гэр бүл, "Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллага"-аар "Товь" ХХК, Хан-Уул дүүргийн "Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллага"-аар "Мөнххада" ХХК, 115 дугаар сургууль, 250 дугаар цэцэрлэг, 21 дүгээр хороо тус тус шалгарсан. Шалгарсан гэр бүлүүдийг хэлтсийн болон хороодын пэйж хуудсуудаар сурталчилсан.	90%
	107	Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 250 өрхийг хөгжлийн үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.	2021-2024	НБХ, ГБХЗХХ	ГБХЗХХ-ийн төсөв	20.0	250 өрх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	75 өрхийн амьжиргаа дээшилж, төслөөс хасагдсан байна.	5.0	НТХ 20.0	2022 онд Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр тус дүүрэгт хэрэгжээгүй тул зорилтот бүлгийн 100 өрхийг сонгон, хэрэгцээний судалгаа авч, дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран 75 өрхийн 345 иргэнд, гэр бүлийн хүчирхийллийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтад 28 иргэн хамруулсан. Сонгон авсан 100 өрхийн гишүүдээс сэтгэл зүйн зөвлөгөө-2, хууль эрх зүй-2, боловсрол-2, хүнс, хувцас хэрэгсэл, түлшний дэмжлэг-74, сувилал-2, бичиг баритжуулах үйлчилгээг 2 иргэнд үзүүлсэн. Цаашид төрийн үйлчилгээ тусламж дэмжлэгт хамрагдах шаардлагагүй, амьжиргаа дээшилсэн 50 өрхийг хассан.	100%
	108	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг ёслолтой бүртгэх	2021-2025	НБХ, СО, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	18.0	2 иргэн хамрагдсан.	100 иргэн хамруулна.	5.0	-	Олон Улсын "Гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан шинээр гэрлэлтээ батлуулсан 1423 хосос 22 хосын гэрлэлтийн бүртгэлийг ёслолтой бүртгэх арга хэмжээг зохион байгуулсан.	50%
4.5.2 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн авьяас хөгжүүлэх сургалт, дүгуйланг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудын чөлөөт цагт зориулсан танхим нээж соёлын үйлчилгээ үзүүлнэ.	109	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд хөгжиж, сурч боловсрох таатай орчин бий болгох, үндэсний хэл соёл, уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	НБХ, БХ, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	170.0	-	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	-	Дүүргийн төсөв 343.25	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 зорилтын 20 үйл ажиллагааны хүрээнд 43 төсөл арга хэмжээ төлөвлөн бүрэн хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд "Хүүхэд бүрийг сурч, хөгжих, төлөвших, тэгш боломжоор хангах" зорилтын хүрээнд 21 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж 18 сургууль, 22 цэцэрлэгт компьютерийн техник хэрэгсэл, гал тогооны жижиг хэрэгсэл, тоглоом, хивс нийлүүлвэл /274.9 сая/. "Соёл, урлаг, спортоор дамжуулан хүүхдийн бие бялдар, авьяасыг хөгжүүлэх" зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хэрэгжүүлж 60 дугаар сургууль "Уран хэлхээ" бүхгийн чуулгын сурагчдад дэмжлэг үзүүлэх /1.2 сая/, Олон улсын хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан зорилтот бүлгийн хүүхдүүдэд баярын бэлэг /67,15 сая/ гардуулах арга хэмжээг зохион байгуулан ажилласан.	100%
4.5.3 Төр хувийн хэвшлийн түншлэлээр залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	110	Залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" байгуулж ашиглалтад оруулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУХ	Нийслэл, дүүргийн төсөв	3,600.0	-	Зураг төсөв батлагдаж, шаардагдах санхүүжилтыг батлуулна.	1,000.0	Дүүргийн төсөв 28.0	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу гэр бүл амрах зориулалт бүхий "Эко зуслан"-ийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Эрхэс констракшн ХХК шалгаран гэрээ байгуулсан. Загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Нийт 402 зуслангийн сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгуламж төлөвлөгдсөн. "Эко зуслан"-ийн ажлын зураг боловсруулагдаж байна.	70%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
	111	Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулах	2021-2024	НБХ	Дүүргийн төсөв	28.0	500 залуу чуулга уулзалтад оролцсон.	500-аас доошгүй залуучуудыг чуулга уулзалтад оролцуулна.	7.0	-	Залуучуудын Үндэсний чуулганы дэд хэлэлцүүлгийг "Залуучуудын оролцоо-Хөдөлмөр эрхлэлт" сэдвээр 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр танхим болон цахимаар зохион байгуулж 77 залуучууд хамрагдаж, хэлэлцүүлгээс гарсан 25 санаачлагыг үндэсний чуулганд хүргүүлж, 16 санал дэмжигдсэн. "Нийгмийн хөгжилд эрчүүдийн оролцоо, манлайлал" дүүргийн дэд хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, 80 залуучуудыг хамруулсан.	30%
4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	112	Дүүргийн хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд залуучууд идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй хариуцалагатай иргэн болоход олон талт дэмжлэгийг үзүүлнэ	2021-2024	НБХ, ГБХЗХХ, ЦШ	Дүүргийн төсөв	50.0	-	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	-	Дүүргийн төсөв 23.8	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 зорилт, 8 үйл ажиллагааны хүрээнд 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулах" зорилтын хүрээнд "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх сургалт, хэлэлцүүлэг" /4.9 сая/, "Залуу гэр бүл, гэдний онцлог харагцээнд нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд "Эзж бол ертөнц" төсөл /14.9 сая/, "Залуучуудад эх орноороо бахархах, байгаль орчноо хамгаалах экологийн боловсролыг эзэмшүүлэх" зорилтын хүрээнд Зуны дифлимийн XIV наадамд Чөлөөт бөхийн төрөлд оролцох тамирчинд 4.0 сая төгрөгийн санхүүжилт олгов.	90%
4.5.5 Хараа хяналтгүй, Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулж, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	113	Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	2021-2024	НБХ, ГБХЗХХ, ЦГ	ГБХЗХХ-ийн төсөв	4.0	4 удаагийн арга хэмжээгээр хараа хяналтгүй 54 хүүхдийг илрүүлж асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн.	4 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.	1.0	-	Хүүхдийн эрхийг хамгаалах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамжны нөхцөлд байгаа болон эцэг эхийн хараа хяналт сул, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх, эрсдэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор гудамж талбай, худалдааны төв, зоогийн газар, авто угаалга, хойгын цэг, морины жүчээ, цахим тоглоомын газрууд, хүүхдүүд хараа хяналтгүй сэлгүүцэх эрсдэлт газруудад 4 удаагийн илрүүлэг, хяналтын арга хэмжээ зохион байгуулж, 11 хүүхдийг илрүүлж, 9 хүүхдийг ар гэрт нь эргэн нэгтгэж, хяналт тавин ажиллаж байна. Мөн 2 хүүхдийг асрамж халамжийн төвд хүлээлгэн өгсөн. Өмнө оны мөн үетэй харьцуулахад хараа хяналтгүй хүүхдийн тоо 85 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100%
4.5.6 Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн "Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	114	"Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	ТЗУХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	Дүүргийн төсөв	43.0	-	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	-	Дүүргийн төсөв 33.1	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 зорилт, 8 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд "Архигүй орчин" тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, эргүүлийн баг ажиллуулах, иргэдийн идэвхийг урамшуулах, мэргэжлийн байгууллагуудын сургалт, олон нийтийн хэлэлцүүлэг, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр арга хэмжээнүүд тус тус хэрэгжүүлж, төсөв шаардлагатай Замын цагдаагийн хэлтсийн "Шинээр томилогдсон албан хаагчдыг техник хэрэгсэлээр хангах төсөл", 6 дугаар хорооны "Архигүй орчин" төслүүдэд 33,159,000 төгрөгийг зарцуулсан.	50%
	115	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжих аян зохион байгуулна.	2021-2024	НБХ, ГБХЗХХ, ЦГ, ЭМТ	Дүүргийн төсөв	40.0	Давхардсан тоогоор хамтарсан багын 687 гишүүн хамрагдсан.	4-с доошгүй сургалт зохион байгуулсан байна.	10.0	-	Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах 2 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 24 хорооны хамтарсан багийн гишүүдэд ажлын байранд мэргэжил арга зүйн зөвлөн туслха үйлчилгээг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах 4 удаагийн арга хэмжээнд хамтарсан багийн давхардсан тоогоор нийт 262 гишүүнийг хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 15 иргэнд сэтгэл зүйн булгийн болон ганцаарчилсан зөвлөгөөг өгсний дүнд архины эмчилгээнд 2 иргэн, урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээнд 5 иргэн сайн дураараа хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл болон давтан дуудлагатай нийт 1027 иргэнийг хорооны хамтарсан баг байнгын хяналтад аван ажиллаж байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
4.5.7 Тусгай хэрэгцээт иргэд, ахмад настан болон залуу ээжүүд зэрэг нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн сайн дурын олон талт дэмжлэг үзүүлэх "Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	116	"Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	2021-2024	НБХ, ГБХЗХХ	ГБХЗХХ-ийн төсөв	20.0	-	6-аас доошгүй бүлгэм байгуулагдсан байна.	5.0	Дүүргийн төсөв 1.65	Өсвөр насны эрт жирэмсэлсэн ээжүүд болон залуу ээжүүдэд гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны чадвар олгох, бүлгийн уулзалтаар дамжуулан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх "Тусч найзууд" бүлгийг байгуулан уулзалт, сургалтыг 4 бүсэд зохион байгуулж, 103 залуу ээжийг хамруулж, 4 бүлэг байгуулагдсан. Бүлгийн гишүүдийг багийн болон ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулснаар хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтын сургагч багш болсон.	90%
4.5.8 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	117	Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, боломж баталгааг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадурхайлтаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	НБХ, ГБХЗХХ	Дүүргийн төсөв	70.0	Үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	20.0	Дүүргийн төсөв 10.0	Жендэрийн дэд хөтөлбөрийг Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлуулсан. Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 12 сургуулийн ахлах ангийн 1100 сурагчдын дунд үерхэл нөхөрлөл, бэлгийн боловсрол, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, жендэрийн зөв хандлагыг төлөвшүүлэх зорилготой "Нандин үерхэл" аяныг 2022 оны 2, 3 дугаар сард зохион байгуулсан. 2022 оны 3 дугаар сард "Харилцан хүндэтгэе" аян зохион байгуулж, 2 удаагийн сургалтад нийт 93 иргэнийг хамруулж, жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг цахим орчинд 7817 иргэнд түгээж, 116 share авсан. Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр нийт 2 аян, 7 сургалт зохион байгуулж нийт 1699 хүнийг хамруулсан.	100%
БҮЛГИЙН ДУНДАЖ ХУВЬ												91%
5.1 Газрын харилцаа												ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ
5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.	118	Хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2024	ГЗБА, УБХ	-	-	Дүүргүүдэд дэд ажлын хэсэг байгуулагдсан.	Иргэн, хуулийн этгээдийн хаягийг шинэчлэх ажлыг зохион байгуулах 40 хувь.	-	-	Засгийн газрын хаягийн мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2022 оны 18 дугаар тогтоолыг үндэслэн, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1413 дугаар захирамжаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас боловсруулсан гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн мэдээллийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, нийслэл, дүүргийн хаягийн мэдээллийн сангаар зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх, холбогдох стандартын дагуу хаяжуулах, тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, НЗДТГ-ын Даргын дэд ажлын хэсэг байгуулах тухай 2022 оны А/205 дугаар тушаалаар ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, дэд ажлын хэсгүүдийг тус тус баталсан. Тус ажлын хүрээнд нийт 20 үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, нийтийн эдлэлбэрийн гудамж, зам талбайд байршуулах хаягийн тэмдэг тэмдэглэгээний судалгаа, төсвийн тооцоот гаргах, зуслан гэр хороололд байршуулах хаягийн тэмдэг тэмдэглэгээний судалгаа, төсвийн тооцоо гаргах, барилга байгууламжийн гадна хаягийн тэмдэг тэмдэглэгээний судалгаа, төсвийн тооцоо гаргах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг нийслэлийн хот байгуулалтын мэдээллийн сан, ГЗБГЗЗГ, УБЕГ-ын мэдээллийн сантай нэгтгэх замаар дундын мэдээллийн санг үүсгэх, бусад цахим системүүдийн хаягийн системтэй уялдуулах ажлыг зохион байгуулах, нийслэлийн хаягийн зураг, гудамж зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаяжуулах журмыг шинэчлэн НИТХ-аар хэлэлцэн батлуулах ажлууд шат дараатайгаар хийгдэж байгаа бөгөөд 2023 онд нийслэлийн хэмжээнд гадна хаягийн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу байршуулах ажлыг зохион байгуулах, шинэчлэсэн хаягийг олон нийтэд сурталчлах ажлууд хийгдэнэ.	70%
	119	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг эзэнжүүлэх	2021-2024	ГЗБА	-	-	Нийт 102 ширхэг цэг тэмдэгт байдаг хамгаалалтыг хариуцах эзэнгүй.	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлж гэрээ байгуулах ажлын 30 хувь.	-	-	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх ажлыг Инженер геодези ХХК гүйцэтгэж 90 цэг, тэмдэгт авсан. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлэх гэрээний байгуулах ажил Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, геодези зураг зүйн газарт хийгдэж байна.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.1.2 "Орц-Гарц" арга хэмжээг хэрэгжүүлж, гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг шийдвэрлэж түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.	120	Дүүргийн хэмжээний Гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн судалгаа гаргаж, зөрчлийг арилгуулах "Орц-гарц" арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ГЗБА, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүргийн төсөв	-	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/513 дугаар захирамжийн хүрээнд 27 байршлаас 20 байршлыг бүрэн чөлөөлж, ажлын явц 93.2 хувьтай.	Зөрчлийн тоо бууруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.	-	НТХО 797.0 ДТХО 536.0	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар "Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжаар Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 19 байршлын 190 гараж, 58 байршилд 9491 урт метр хайс хашаа бүрэн чөлөөлж орц, гарцуудыг чөлөөлж ажиллалаа. Гараж буулгаж газар чөлөөлсөн талбайг тохижуулах ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 байршилд /2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд/ авто зогсоол, дулиан зам, явган хүний зам, чийрэгжүүлэлтийн талбай, ногоон байгууламж бүхий тохижилт, дүүргийн төсвийн хөрөнгөөр газар чөлөөлсөн 4 байршилд 1185 м.кв талбайд авто зогсоол, явган хүний байгуулж, сургууль, цэцэрлэг орчмын зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлсэн.	100%
5.1.3 Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	121	Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх	2021-2024	ГЗБА	-	-	НЗД-ын захирамжаар 12 иргэн, аж ахуйн нэгж, ДЗД-ын захирамжаар 49 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож шийдвэрлэсэн.	Хуулийн хэрэгжилтийг хангах, газар ашиглалт сайжрах.	-	-	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/143, А/236, А/254, А/339, А/446, А/479 дүгээр захирамжаар гэр бүлийн хэрэгцээ, төмс хүнсний ногооны зориулалтаар газар эзэмших эрх олгосон боловч газраа зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаагүй, газар дээрээ амьдраагүй, татан буугдсан, газар эзэмших эрхийг дуусгавар болгох хусант гаргасан 28 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг тус тус хүчингүй болгосон.	100%
5.1.4 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	122	Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх	2021-2024	ТНБХХУ Х, ГЗБА	-	-	НЗД-ын 2020 оны А/715 дугаар захирамж гарсан.	Гарсан зөрчлийн 45-аас доошгүй хувьд стандарт хангуулж ажиллана.	-	-	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/211 дүгээр захирамжийн хүрээнд нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй амьдарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх 4 ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт цахилгааны ил гарсан утасгүй гэрэлтүүлгийн 2100 метр утас, таггүй гэрэлтүүлгийн 464 ширхэг шонг засварлаж аюулгүй байдлыг хангуулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй барьсан 18 хашаа, хайсыг стандартын шаардлагад нийцүүлэх талаар хугацаатай мэдэгдэл өгч зөрчил арилгуулах, үүсмэл болон хур хог хаягдал үүссэн 43 цэгийн хог хаягдлыг цэвэрлүүлж устгуулах, 157 эзэнгүй золбин нохой устгуулах, барилгын аюулгүй байдлыг хангаж ажиллаагүй захиалагч, гүйцэтгэгч бүхий 20 аж ахуй нэгж байгууллагуудад нийт 80 заалттай 10 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч зөрчлийг арилгуулах арга хэмжээг тус тус хэрэгжүүлж, төрийн өмчийн болон, төрийн бус өмчийн нийт 176 ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг хийсэн.	100%
	123	Стандартын шаардлага хангасан гэрэлтүүлгийг шаардлагатай байршлуудад байршуулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	1,500.0	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан.	Стандартын шаардлага хангасан ширхэг гэрэлтүүлгийг байрлуулсан байна.	200.0	УТХО 70.0 НТХО 80.0 ДТХО 1,200.0	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд 12 хорооны нутаг дэвсгэрийн гэрэлтүүлэг шаардлагатай нийт 494 цэгт гэрэлтүүлэг шинээр суурилуулж орчны эрүүл, аюулгүй байдлыг хангаж ажиллалаа. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам дагуу шинээр 30 ширхэг 2 толгоотой гэрэлтүүлэг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх авто зам дагуу шинээр 34 ширхэг 2 толгоотой гэрэлтүүлэг, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 3, 4, 11, 13, 14, 15, 19, 20, 21 дүгээр хороонд шинээр 430 ширхэг гэрэлтүүлэг тус тус сууриуулсан.	100%
5.1.5 Биокомбинат, Туул, Өлзийт хороодод нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулж, бус нутгийн газар ашиглалтыг сайжруулна.	124	Эзэмшлийн газраа 2-оос дээш жил ашиглаагүй иргэд хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгуулж, дахин олголт хийх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	2022-2024	ТГУХ, ГЗБА	Дүүргийн төсөв	-	-	Судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулна.	-	-	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 ба түүнээс дээш жил ашиглаагүй 40 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гарган мэдэгдэх хуудас хүргүүлэн, 3 иргэнд сонсох ажиллагаа хийгдсэн.	100%
125	Түгээмэл тархацтай ашигт малын олборлолтын улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх ажлын эдийн засгийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.	2021-2024	ТНБХХУ Х, МХХ	Дүүргийн төсөв	195.0	310,6 га газар уул уурхайн олборлолтын нөлөөгөөр эвдэрсэн байна.	Нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээг тодорхойлон, нөхөн сэргээх ажлын техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нөхөн сэргээлт хийнэ.	50.0	-	Дүүргийн 12, 13 дугаар хороодын нутаг дэвсгэрт уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлж, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд тус ажлын дүгнэлтээр уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй лицензийн талбайн орчимд эвдрэлд сул өртсөн 943.30 га, дунд зэрэг өртсөн талбай 257.04 га, эвдрэлд хүчтэй өртсөн 1126.48 га нийт 2326.48 га талбай эвдрэлд өртсөнөөс 35,3 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 12,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт, нийт 47,8 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	100%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин 2022 он			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.1.6 Туул тосгон Биокомбинат орчмын хайрганы карьераас үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ.	126	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	2021-2024	ТНБХХУ Х, МХХ, ЦГ	Дүүргийн төсөв	120.0	"Нөхөн сэргээлт 2020" аяны хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 91 аж ахуйн нэгж байгууллагын талбайд хяналт шалгалт явуулсан.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлыг тогтмол зохион байгуулна.	30.0	ДТХО 81.0	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, дүүргийн Засаг даргын 2022 оны А/77, А/146 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч 14 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан бөгөөд 4 аж ахуйн нэгж хангалттай, 10 аж ахуйн нэгж, байгууллага хангалтгүй үнэлгээ авсан ба түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоосон. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд хамтарсан шалгалт хийж, усны зөвшөөрөлгүй 5 аж ахуй нэгж, хог тээврийн гэрээ байгуулаагүй 4 аж ахуй нэгжийн зөрчлийг арилгуулсан. Хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 10 дугаар хороо, Морин давааны зүүн замд байрлах 4 замын уулзвар дээр хяналтын түр кабоныг байгуулж 4 албан хаагч, 14-р хороо, Өлзийтийн шинэ шалган бүртгэх товчоонд тус газрын Замын цагдаагийн хэлтсээс 3 ээлжээр 3 алба хаагч 24 цагаар тус тус хяналт тавин ажиллаж байна. Нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээг хэмжигч "Зөөврийн электрон пүү"-г дүүргийн 13-р хороо, Био комбинатын зам, Таван толгойн постонд байрлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж нийт 410 тээврийн хэрэгсэл шалгаж Замын хөдөлгөөний дүрмийн 24 дүгээр зүйл "Ачаа тээвэрлэх" журам зөрчсөн 145 жолоочид 7250 нэгж, нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээг хэтрүүлсэн 124 жолоочийг 18600 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгуулийн арга хэмжээ тооцон зөрчлийг арилгуулж ажилласан.	100%

5.2 Орон сууц

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг иргэд оршин суугчдын харилцан ойлголцлын үндсэн дээр талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	127	Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй, нам давхрын болон амины сууцны хороолол болгох ажлыг тууштай хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ	Улс, нийслэл төсөв	-	Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 48 дугаар тогтоолоор 4-8 дугаар хороодын 168 га газрыг дахин төлөвлөн барилгажуулахаар баталсан.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.	-	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.9 га талбай буюу 5791 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. Үүнд: 4 дүгээр хороо 34-р сургууль орчим 16.5 га 159 нэгж талбарт "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ 3 талт гэрээ байгуулах ажлын явц 85% буюу 136 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулан 108 нэгж талбар газар чөлөөлсөн. Үүнээс: Буянт ухаа 1 орон сууцны хороололд-17 нэгж талбар, Буянт-Ухаа 2 хороололд-65 нэгж талбар нийт 82 нэгж талбарын иргэдэд орон сууц олгосон. 26 нэгж талбарт түрээсийн зардал олгож байна. Е-хэсэг 39.9 га 938 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 60% буюу 616 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан, нийт 118 нэгж талбарт газар чөлөөлт хийгдэж 3 блок 360 айлын орн сууц ашиглагданд орсон. 5 дугаар хороо Д хэсэг 34 га 810 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц-10% буюу 80 нэгж талбарын иргэдтэй байгуулсан. 2023 оны 05 дугаар сард барилга угсралтын ажил эхлэнэ, 41-р сургууль орчим 10.55 га 153 нэгж талбар "Ама констракшн" ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 60% буюу 93 нэгж талбарын иргэдтэй байгуулсан, эхний ээлжийн 11 нэгж талбарт газар чөлөөлтийн ажил хийгдсэн. 6 дугаар хороо Г хэсэг 54.5 га 1200 нэгж талбарт "Голден мартин" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10% буюу 118 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн зураг 95%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 7 дугаар хороо В хэсэг 40.9 га 630 нэгж талбарт "Ланкастер" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 11.5% буюу 72 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2022оны 09 дүгээр сарын 20-нд батлуулсан. 8 дугаар хороо А хэсэг 45.9 га 756 нэгж талбарт "Монголиан инвестмент пропорешн" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 10% буюу 68 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан, Мөн А хэсэг 11.5 га, 134 нэгж талбарт "Ажнай цэгц" ХХК 3 талт гэрээ байгуулах ажлын явц 80% буюу 107 нэгж талбарын иргэдтэй байгуулсан эхний ээлжийн 7 нэгж талбарт газар чөлөөлтийн ажил хийгдэж 2 блок 192 айлын орон сууцны барилгын суурийг тавьсан. Б-хэсэг 46.1 га 788 нэгж талбарт "Ивээлт цамхаг констракшн" ХХК 3 талт гэрээний байгуулах ажлын явц 35% буюу 234 нэгж талбарын иргэдтэй гэрээ байгуулсан, эхний ээлжийн 15 нэг талбарт газар чөлөөлтийн ажил хийгдсэн. Барилгажих хэсгийн техникийн нөхцөл хүссэн. Мөн Б-хэсэг 15 га талбайд дахин төлөвлөлт хэрэгжүүлэх "Баярс ХХК"-ийн батламжийг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/156 дугаар захирамжаар цуцалсан. 2023 онд тус байршилд төслийн сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна.	100%	

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлнэ.	128	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны хэрэгжиж буй төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ	Улс, нийслэл төсөв	-	7 багц арга хэмжээ явагдаж байна.	Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны эрчимжүүлнэ. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцад амьдарч байгаа иргэдээс санал авна.	-	-	Дүүргийн АШХНЗОС-ны 34 барилга байгаагаас 29 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 615 айлын 23 орон сууцыг буулган 1539 айлын 10 орон сууц ашиглалтад оруулж, 444 айлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангасан. 2022 онд АШХНЗОС дахин барилгажуулах ажлын явц дараах байдалтай байна. Үүнд: • ХУД 01-р багц "Фүжи девелопмент" ХХК Нэхмэлийн 11, 16 дугаар байр буулган барилгын суурийн ажил хийгдэж дууссан. Суурийн цутгалтын ажил хийгдсэн • ХУД 02-р багц "Хару констракшн" ХХК Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байр буулгалтын ажил хийгдсэн. • ХУД 02-р багц "Эм Эм Жи Капитал" ХХК АШҮН 26, Нэхмэлийн 3-р байр, 36 айлын орон сууцыг буулган 253 айлын 1 орон сууц ашиглалтад оруулсан. • ХУД 10-р багц "Шинэ гэр түншлэл" ХХК 36А, 36Б дугаар байрны дахин төлөвлөлтийн ажил зогссон шүүхийн маргаантай байна. • ХУД 11-р багц Монтекарло гоулд" ХХК Нийслэлийн Засаг даргын А/80 дугаар захирамжаар батламжаа авсан. Сурьез 20 дугаар байрны дахин төлөвлөлтийн ажлын 3 талд гэрээ байгуулах ажил 80%-тай буюу 31 айлтай гэрээ байгуулсан. 2022 онд Хан-Уул дүүргийн 3, 10, 12 дугаар хорооны 5 ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 1,13 га нэгж талбарт төслийн сонгон шалгаруулалтыг нэг удаа зарласан. Үүнд: /ХУД-06-р багц 10 дугаар хорооны Нисэхийн 34, 35 дугаар байр 0.52 га, ХУД-08-р багц 12 дугаар хорооны Биокмбинатын 39 дүгээр байр 0.26 га, ХУД-09-р багц 3 дугаар хорооны Арьс ширний 31 дүгээр байр 0.2 га, ХУД-13-р багц 3 дугаар хорооны Талхны 20 дугаар байр 0.15 га/. Тус сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч шалгараагүй.2023 онд төслийн сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын дагуу 1 дүгээр хороо 18, 19, 20,21,21- дугаар байр, 3 дугаар хороо Хараагүйчүүдийн 48 дугаар байр, 7 дугаар хороо 16 дугаар байр, 20 дугаар хороо дэвшлийн 36 дугаар байрны оршин суугчдаас саналыг авч нэгтгэн "Хот байгуулалт хөгжлийн газар" уламжилсан.	100%
5.2.3 Нийтийн зориулалттай хуучин орон сууцнуудыг дулаалах, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	129	Нийтийн зориулалттай хуучин орон сууцны дэвээр, фасад, орчны болон түүний шугам сүлжээний ажлыг насжилт, хэрэгцээ шаардлага болон холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	667.0	-	4-өөс доошгүй байрны дэвээр, фасадын ажил хийгдсэн байна.	-	УТХО 1,051.0 ДТХО 1,927.0	Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 дүгээр хороо 25 дугаар байр, 3 дугаар хороо 1а байр, 10 дугаар хороо 60, 63, 61/1, 61/2, 67 дугаар байр, 13 дугаар хороо 5 дугаар байр, 15 дугаар хороо 60 дугаар байрны дэвэрийн засвар, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 13 дугаар хороонд 2 дугаар байрны дэвэрийн засвар, нийт 10 байрны дэвэрийн засварын ажил гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 8а байр, 30 дугаар байр, 10 дугаар хорооны 2, 61 дүгээр байрнуудын фасад засвар, дулаалга, Улсын төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 39 дүгээр байр, 2 дугаар хорооны 18 дугаар байрны дулаалгын ажил, нийт 6 нийтийн зориулалттай орон сууцны фасад засварыг хийж дулаан алдагдлыг бууруулсан.	100%
5.2.4 Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох газартай хамтран зохион байгуулж, хэвийн найдвартай ажиллагааг хангана.	130	Шаардлагатай байршлуудад гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	45.0	-	2 байршилд гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажил хийнэ.	-	-	Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй ЭХЯ-ны "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд дүүргийн 2 байршилд гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажил гүйцэтгэсэн. Үүнд: 3 дугаар хорооны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг дулаан дамжуулах 2.9 км-ийн урттай, 800 мм-ийн голчтой 5а магистраль шугамыг 1000 мм-ын голчтой болгож өргөтгөн шинэчлэх, 1 км-ийн урттай, 500 мм, 400 мм-ийн голчтой дулааны шугамыг 700 мм-ийн голчтой болгож өргөтгөн шинэчилж, сувагт суулгах барилга угсралтын ажил хийгдэж дууссан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.3 Дэд бүтэц												
5.3.1. Дүүргийн авто замын ачааллыг бууруулах чиглэлээр шинээр авто зам барьж, хороолол доторх авто замд засвар, шинэчлэлт хийнэ.	131	Засварлах, өргөтгөх, шинээр тавих шаардлагатай замын судалгааг гарган авто замын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х, ХУЗ3А ОНӨААТ ҮГ	Улс, нийслэл, дүүрэг төсөв	16,960.0	Дүүргийн 5, 16, 21-р хороонд 3.1 км авто зам тавих ажлын гэрээ байгуулагдан, ажил хэрэгжиж байна.	Зам өргөтгөх, нөхөөс хийх зэрэг засвар үйлчилгээ хийгдэж, шаардлагатай байршилд шинээр 2 км-ээс доошгүй авто зам тавина.	3,960.0	УТХО 1,500 НТХО 1,462 ДТХО 1,448.3	Хан-Уул дүүрэгт 2022 онд шинээр улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,2 км авто зам ашиглалтад оруулсан. Үүнд: 1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хороонд хэрэгжсэн Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.8 км авто зам ашиглалтад орсон. 2. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороо Буянт Ухаа 2 хорооллын урд 0.19 км авто зам, зогсоол орсон. 3. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороо Нисэхийн шинэ эцэст 1040 м.кв талбайд нийтийн тээврийн зогсоолыг ашиглалтад орсон. 4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 17 дугаар хороо Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх 1 км авто замын хөдөлгөөн нээсэн. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажуулуулах хүсэлт өгсөн. 5. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5, 16, 21 дүгээр хороонд он дамжин хэрэгжиж буй 3.2 км авто замын ажлын гэрэлтүүлэг, нэмэлтээр түшиц ханын хийгдэж дууссан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажуулуулах хүсэлт өгсөн. Улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 5,05 км авто замын барилга угсралтын ажил хийгдэж байна. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд хэрэгжиж буй Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголониин төв зам хүртэлх 2.2 км авто замын газар шороо суурийн хийгдэж байна. 2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороонд хэрэгжиж буй Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.65 км авто замын 0.5 км зам тавигдсан. Үлдсэн 0.15 км зам авто замын хэсэг газар чөлөөлөлтийн улмаас хийгдэхэд хүндрэлтэй байна. 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хороонд хэрэгжиж буй Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх 2.2 км авто зам, гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Тотал инж" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Газар шорооны ажил эхэлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй дараах авто замын ажлууд худалдан авах ажиллагааны шатанд байна. Үүнд: 1. 23 дугаар хороо Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл авто замын засвар, шинэчлэлт ажлын тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. 2. 9, 16 дугаар хороонд хатуу хучилттай авто зам тавих ажлын тендер дахин зарлах шатанд. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 139 байршилд 1075,87 м.кв	100%
5.3.2 Төмөр бетон гүүрийн байгууламжийг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, шинэчлэх ажил хэрэгжүүлнэ.	132	Шинээр төмөр бетон гүүрийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2021-2024	ТГУХ	Улс, нийслэл төсөв	353.2	-	Төмөр бетон гүүрийн байгууламжийн зураг төсөв хийлгүүлнэ.	353.2	-	1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх 483.1 у/м авто замын гүүрийн барилга /1 дүгээр хэсэг гүүрийн барилгын ажил/-ын ажлын гүйцэтгэгчээр Мотор сервис ХХК, Туулын гүүр далай ХХК, Тэргүүн саруул зам ХХК түншлэл ажиллаж байгаа бөгөөд гүүрийн байгууламжийн суурийн ажил хийгдэж байна. Ажлын явц 20 хувь 2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 11 дүгээр хороо "Зайсангийн төмөрбетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт /225 метр/-ийн ажил"-ын гүйцэтгэгчээр "ЗМЗ" ХХК ажиллаж байна. Ажлын явц 3 хувь.	100%
5.3.3 Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцыг авто зам дээгүүр барих ажлыг хэрэгжүүлнэ.	133	Наадамчдын авто зам дагуу 1-ээс доошгүй байршилд нүхэн болон гүүрэн гарц байгуулна.	2021-2024	ТГУХ	Улс, нийслэл, дүүрэг төсөв	2,000.0	-	Наадамчдын авто зам дагуу 1 нүхэн гарцыг ашиглалтад оруулна.	1,000.0	Дүүргийн төсөв 3,155.0	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд он дамжин хэрэгжиж "Наадамчдын авто замд явган хүний нүхэн гарц барих" /4 дүгээр хороо, Хүннү молл худалдааны төвийн урд/ ажлын гүйцэтгэгчээр "Туулын гүүр далай" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нүхэн гарцын цахилгаан, дотор засал, гадна шилэн хийцлэл, тохижилтын ажил хийгдэж байна. 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	90%
5.3.4 Сургууль, цэцэрлэгийн гадна талбай болон орон сууцны хотхон доторх шороон хөрс бүхий талбайд авто зогсоолуудыг барьж, байгуулна.	134	Сургууль, цэцэрлэг болон орон сууцны гадна талбайн авто зогсоолыг шинэчлэн сайжруулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	740.0	-	2-оос доошгүй байршилд авто машины зогсоол байгуулсан байна.	200.0	НТХО 797.0 ДТХО 114.0	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй барьсан гараашийн газар чөлөөлж, тохижуулах ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 2 байршилд /2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд/ авто зогсоол, дугуйн зам, явган хүний зам, чийрэгжүүлэлтийн талбай, ногоон байгууламж бүхий тохижилт хийгдсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хороо 67 дугаар цэцэрлэгийн зүүн талд, 2 дугаар хороо 65 дугаар цэцэрлэгийн ард, 75 дугаар сургуулийн хойд талд, 8а байрны баруун талд, 15 дугаар сургуулийн зүүн талд, 10 дугаар хороо 60/1 дүгээр байр гадна талд буюу нийт 5 байршилд 2325 м.кв талбайг авто зогсоол байгуулсан.	100%
5.3.5 Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	135	Сул шороон хөрс бүхий талбайг хатуу хучилттай болгон, тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	400.0	15,653 м2 талбайг зүлэгжүүлж, 48,035 м2 талбайг цардамалжуулж хатуу, хучилттай болгосон.	10,000 м2 -аас багагүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлнэ.	100.0	-	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтаар болон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг/)	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.3.6 Стандартад нийцсэн дугуйн болон явган хүний замыг шинээр барьж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	136	Явган хүний замыг стандартад нийцүүлэн шинэчлэх болон шинээр явган хүн, дугуйн зам байгуулах замаар иргэдийн явган болон дугуйгаар зорчих хэсгийг сайжруулж, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	1,200.0	2020 онд 2.5 км явган хүний зам, 1.6 км дугуйн зам ашиглалтад оруулсан.	1 км-ээс доошгүй талбайд явган хүн, зам дугуйн байгуулна.	200.0	ДТХО 250.0	Нийслэл, дүүрэг, хувийн хэвшлийн оролцоотой нийт 59 байршилд 1.6 км явган зам шинээр тавьж, 1.8 км явган замыг нөхөж засварлан, 0.65 км дугуйн замыг шинээр тавьж ашиглалтад оруулсан. Үүнд: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хот тохижилтын газар ОНӨААТҮГ 3, 17 дугаар хорооны 2 байршилд газар чөлөөлж шинээр 0.45 км явган зам, 4, 5, 6, 7, 8 дугаар хороо Наадамчдын зам дагуу 0.165 км урт явган замын нөхөөс, засвар хийж, 19 дүгээр хороо Богд хааны ордон музейн зүүн талыг хашааг буулгаж, газар чөлөөлсөн талбайд 0.44 км явган хүний зам, дугуйн зам шинээр тавьсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжсэн орон сууц хороолол дундах явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт, тохижилтын төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 4, 11, 19, 20 дугаар хорооны 9 байршилд шинээр 0.45 км явган зам тавьж, 1, 2, 3, 11, 15, 18, 19 дүгээр хороонд 15 байршилд хуучирч эвдэрсэн 0.98 км явган замын засвар хийж, 15 дугаар хороонд 3 метр өргөнтэй, 210 метр урттай дугуйн замыг шинэчилсэн. Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 12, 15, 16, 19, 20 дугаар хороонд 30 байршилд 0.26 км талбайд шинээр явган хүний зам тавьсан.	100%
5.3.7 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	137	Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийн судалгааг гарган холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар цахилгаан, эрчим хүчинд холбоно.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	525.0	11, 12 дугаар хороонд цахилгааны хүчдэл сайжруулсан.	13, 12, 14 дүгээр хороонд цахилгааны хүчдэл сайжруулсан байна.	500.0	ДТХО 1,704.0	Дүүргийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар 13, 14 дүгээр хорооны цахилгааны хүчдэлийг сайжруулах 2 багц ажлын хүрээнд: 1. 13 дугаар 26 хэсгийн 21 өрх, 14 дүгээр хороо 1, 5 дугаар хэсгийн 223 айл өрхийн цахилгааны хүчдэлийг сайжруулах ажил тус тус хийгдэж улсын комисс ажиллан хүлээн авсан. 2. 14 дүгээр хорооны Өлзийт, Ар хөндлөн, 4, 7 дугаар хэсгийн нийт 151 айл өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 14 дүгээр хороо Гавьжийн шанд хэсгийн 160 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. 12 дугаар хороо Хайрхан хэсэг Сонгино 27 дугаар гудамжны айл өрхийн хүчдэлийн уналтыг сайжруулах ажлын зураг төсвийг "Чандмань хонгор групп" ХХК-аар гүйцэтгүүлж хүлээн авсан.	90%
5.4 Хоггүй Хан-Уул												
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	138	Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	100.0	-	Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	-	ДТХО 4,860.4	2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 зорилт, 16 арга хэмжээнээс, 15 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хог тээврийн 18 машин, зам талбай цэвэрлэх, услах, давс бодис цацах тусгай зориулалтын 2 авто машинаар парк шинэчлэлтийг хийж, хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий 30 ширхэг хогийн сав, хог төвлөрүүлэх 13 ширхэг хогийн сав, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хэрэгцээт газруудад байршуулсан байна. Хог ангилан ялгалтыг эрчимжүүлэх зорилгоор 4 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, 120 сууц өмчлөгчдийн холбоодын 200 гаруй иргэнийг оролцуулж, хогоо ангилдаг сууц өмчлөгчдийн холбоод 2021 онд 71 байсныг 2022 онд 85 болгож нэмэгдүүлсэн. "Хоггүй Хан-Уул дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх боломж шийдэл" хэлцүүлгийг зохион байгуулж, хог тээврийн байгууллагууд, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, хоёрдогч түүхий эд авах цэг, томоохон үйлдвэрүүд, мэргэжлийн ТББ, олон улсын байгууллагын төлөөлүүдийг оролцуулж, санал шийдэл гаргасан. Дүүргийн хог тээвэрлэлт, зам цэвэрлэгээ хариуцсан 4 ОНӨААТҮГ, 2 аж ахуйн нэгж, байгууллагын ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, ажиллаж байгаа бөгөөд 2022 оны байдлаар нийт 123,952.65 тонн энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хүргэж, 46.385 тонн хог хаягдлыг дахин боловсруулж ашигласан байна. Нийтийн эзэмшил газрын төвлөрсөн хогийн цэг, хог хаягдал ихээр үүсдэг 90 байршилд хяналтын камер байрлуулах ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.	100%
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	139	Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	160.0	Дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан.	10-аас доошгүй удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан байна.	40.0	ДТХО 30.0	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/56 дугаар захирамжаар "Хоггүй Хан-Уул 2022" аян зохион байгуулж дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 280 сууц өмчлөгчдийн холбоодын 24920 хүн оролцож, 863,876 м.кв талбайгаас 1227.2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	140	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбайг тогтмол ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.	2021-2024	ТНБХХУ Х	Дүүргийн төсөв	600.0	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 126,854м2 гудамж, талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 150,000м2 гудамж талбайг ариутгаж халдваргүйжүүлнэ.	150.0	ДТХО 30.4	Дүүргийн Засаг даргын А/419, А/529 захирамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбай, хогийн цэг, тоглоомын талбай, сургууль, цэцэрлэг, зах худалдааны төвүүд орчмын нийт 158,200 м.кв талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	100%
5.4.2 Хог хаягдлын тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын авто машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	141	Хог хаягдлын тээврийн машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл дүүргийн төсөв	5,196.0	Хог тээвэрлэлтийн 3 байгууллагад 32 хог тээврийн машин ажиллаж байна.	-	-	ДТХО 4,600.9	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 8 автомашинаар парк шинэчлэлт хийсэн. Үүнд хог тээврийн 4 байгууллагад Хьюндай HD-72 маркийн 6 м3 хог шахаж ачих зориулалтын 6 автомашин, зам цэвэрлэгээ усалгааны хосолмол үйлдэлтэй 2 автомашиныг тус тус хүлээлгэн өгсөн. Мөн дахин шинээр Хьюндай HD-78 маркийн 6 м3-ийн 7 автомашин, Хьюндай HD-170 маркийн 14. м3-ийн 4 автомашин буюу нийтдээ 11 ширхэг хог шахаж ачих зориулалтын автомашин тээвэрлэлтийн шатанд байна. 2022 оны 12 дугаар сард багтаан хүлээлгэн өгнө.	100%
5.4.3 Гэр хорооллын айл өрхүүдийг үнс хадгалах савтай болгох, ангилан ялгах, тусад нь тээвэрлэх ажлыг зохион байгуулна.	142	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	2021-2024	ТНБХХУ Х	Улс, нийслэл дүүргийн төсөв	-	Ахлын хэсэг байгуулагдсан.	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	-	-	Хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх боломж шийдэл" хэлцүүлгийг зохион байгуулж, хог тээврийн байгууллагууд, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, хоёрдогч түүхий эд авах цэг, томоохон үйлдвэрүүд, мэргэжлийн ТББ, олон улсын байгууллагын төлөөллүүдийг оролцуулж, санал шийдэл гаргасан.Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр Улаанбаатар зам засвар арчлалтын газар, "Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран үнсийг тусд нь ангилах зөвлөмж бүхий 500 ширхэг уриалга, тараах материалыг гэр хорооллын айл өрхүүдэд тарааж мэдээлэл хүргэсэн.	70%
5.5 Инженерийн бэлтгэл арга хэмжээ												
5.5.1 Шинээр барих болон өргөтгөн шинэчлэх авто замын дагуу зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулна.	143	Төсвийн хөрөнгөөр шинээр хийгдэх авто замыг борооны ус зайлуулах шугам сүлжээтэйгээр төлөвлөн хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, нийслэл, дүүрэг төсөв	-	-	Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна.	-	НТХО 2,659.7	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3 дугаар хороо Ажилчны гудамжнаас Ярмагийн гүүр хүртэл 705 урт метр авто замын ус зайлуулах шугам тавих, 1 дүгээр хороо, Чимэд-Осорын гудамжинд 199.5 урт метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. Мөн шинээр 17 дугаар хороо Ханхилс хотоноос Зайсангийн гүүр хүртэл 1.0 км, 20 дугаар хороо Номин Юнайтедийн баруун талаар Б.Шаравын гудамж хүртэл 0.9 км, Ээрмэлийн гудамжны 0.4 км хатуу хучилттай авто зам, дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороонд 3800 м.кв авто зам, зогсоолын ажлыг ус зайлуулах шугам сүлжээтэй гүйцэтгэсэн.	100%
5.5.2 Үерийн хамгаалалтын далан сувгийг шинэчлэх болон шинээр барьж байгуулна.	144	Үер, усны аюулд өртдөг болон өртөх боломжтой бүсийн судалгааг гарган ус зайлуулах далан, сувгийг байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х, ОБ	Улс, нийслэл, дүүрэг төсөв	100.0	-	Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна.	-	НТХО 2,659.7	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр 1.8 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж барих, 12 дугаар хороонд 180 урт метр Туул голын далан өндөрлөх, эргийн бэхлэгээ хийх ажил, 10 дугаар хороо 300 урт метр Нисэхийн ус зайлуулах сувгийг засварлан шинэчлэх зэрэг 4 байршилд ус зайлуулах далангийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7, 8 дугаар хороонд бороо орсны дараа ус хэмжээгээр тогтож, иргэд зорчих боломжгүй болдог 17 дугаар гудамжинд туузан хашлага, авто машины орц гарц бүхий 300 урт метр ус зайлуулах сувгийг шинээр байгуулж, 2 талын шороон замыг хусаж, дайргаар засварласан.	100%
5.5.3 Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж, хамгаалалтын бүсийн газрыг албажуулна.	145	Үерийн аюултай бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х, ГЗБА, ОБ	Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	Үерийн аюултай бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй бусан нийт 253 айл өрх, албан байгууллага.	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.	-	-	Дүүргийн нутаг дэвсгэрт шар усны үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй суурьшсан 245 айл өрхийн судалгааг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт газрын харилцаатай холбогдон гэрч буй зөрчил маргааныг арилгах, таслан зогсоох 47 зөрчлийн дуудлага ирсэний дагуу газар дээр нь тухай бүр очиж зөрчлийг арилгасан.	100%
5.6 Усан хангамж, ариутгах татуурга												
5.6.1 Аж ахуйн нэгж, байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	146	Туул голын сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана.	2021-2024	ТНБХХУ Х	-	-	5 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях зөвшөөрөл олгосон.	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, хяналт тавьж ажиллана.	-	-	Туул голын сав газрын захиргаанаас ирүүлсэн "Хаягдал ус хаях" дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн дагуу 5 аж ахуй нэгж, 1 иргэнд ус хаях зөвшөөрөл шинээр олгож, гэрээ байгуулж, 1 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг сунгасан. Усны газрын дүгнэлтийг үндэслэн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ТӨХК-д хаягдал усны цэг тогтоож, хяналт тавин ажиллаж байна. Зөвшөөрөл олгосон байгууллагуудын мэдээллийг дүүргийн Татварын албанд хүргүүлэн татвар төлөгчөөр бүртгүүлсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг/)	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								2022 он				
								Зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Төсөв (сая.төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төгрөг)		
5.6.2 Ундны усны эх үүсвэрийн гүний худаг тоолуургүй айл өрх, аж ахуйн нэгжийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцоно.	147	Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл" олгож гэрээ байгуулж, хяналт тавих, усны мэдээллийн санд бүртгэнэ.	2021-2024	ТНБХХУ Х	-	-	11 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус ашиглах зөвшөөрөл олгосон.	Ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэж, хяналт тавьж ажиллана.	-	-	Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 6 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгож, усны мэдээллийн санд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна. Тус байгууллагуудын мэдээллийг дүүргийн Татварын албанд хүргүүлэн татвар төлөгчөөр бүртгүүлсэн.	100%
5.6.3 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	148	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улсын төсөв	-	Зайсан орчмын орон сууцнуудыг усан хангамжид холбох ажлын явц 30%-тай.	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	-	УТХО 1,500.0 НТХО 3,100.0	Улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн системийн ажлын гүйцэтгэгчээр "Баткомплект" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Цэвэр усны 219 мм-ийн голчтой 3 км урт хос шугамын ажил, 500 м.куб багтаамжтай усан сангийн ажил тус тус хийгдсэн. Мөн 21 дүгээр хороо Буянт Ухаа-2 хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар эзлэгийн ажлын гүйцэтгэгчээр "Жаргалант дулаан" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ариутгах татуургын 400, 500 мм-ийн голчтой 1,4 км шугамын ажил хийгдсэн. Яармаг суурьшилын шинэ төвийн 2 дугаар эзлэгийн ариутгах татуургын шугам, гадна бохир усны насос станц /10м³ цооногийн хамт/-ын ажлын гүйцэтгэгчээр "Модерн хас" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 600 мм-ийн голчтой 328 метр урт ширмэн хоолойн ажил хийгдсэн. Гадна бохир усны насос станц, тоноглол 10м³ цооногийн ажил хийгдэж байна. 2023 оны 7 дугаар сард ашиглалтад орно. Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй эзэлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй ЭХЯ-ны "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг дулаан дамжуулах 2.9 км-ийн урттай, 800 мм-ийн голчтой 5а магистраль шугамыг 1000 мм-ын голчтой болгож өргөтгөн шинэчлэх, 1 км-ийн урттай, 500 мм, 400 мм-ийн голчтой дулааны шугамыг 700 мм-ийн голчтой болгож өргөтгөн шинэчилж, сувагт суулгах барилга угсралтын ажил хийгдэж дууссан.	100%
5.6.4 Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.	149	Смарт ажиллагаатай худаг байгуулна.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	-	2-оос доошгүй смарт ажиллагаатай худгийг байгуулна.	-	НОНХС 80.0 ДТХО 60.0	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангын хөрөнгөөр 11 дүгээр хороонд 1, 14 дүгээр хороонд хуучин 5 гүний худгийн смарт ажиллагаатай болгосон. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд шинээр смарт ажиллагаатай 1 гүний худаг шинээр байгуулсан.	100%
5.6.5 Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож баталгаажуулна.	150	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	2021-2024	ТНБХХУ Х, ГЗБА	Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	• Яармагийн гүүрнээс маршалын гүүр хүртэлх ундны усны онцгой хамгаалалтын бүсэд өртсөн 50 нэгж талбар, • "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр"-ийн трассэ өртсөн 109 нэгж талбарын судалгааг тус тус нэгтгэн гаргасан.	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.	-	-	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд шинээр газар эзэмших эрх олгоогүй.	0%
5.6.6 Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизмар хангалт хийж засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгаж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	151	Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2021-2024	ТГУХ, ТНБХХУ Х	Улс, Нийслэл, дүүргийн төсөв	-	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.	-	ДТХО 272.2	Өвөлжилтийн бэлтгэл ажлын цэвэр, бохир усны шугам, сүлжээний засварын ажлын хүрээнд 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: 1 дүгээр хороо 52 дугаар сургуулийн дулааны уезель; 5 дугаар хороо 29 дугаар цэцэрлэгийн сантехникийн засварын ажил; 9 дүгээр хороо 134 дүгээр цэцэрлэгийн хэрэглээний халуун усны шугамын ажил; 13 хороо 26 дугаар сургуулийн гадна бохирын шугам дулаалах ажил; 13 хороо 144 цэцэрлэгийн 1, 2 дугаар байрны сантехникийн хэрэгсэл нийлүүлэх; 16 дугаар хороо 89 дугаар сургуулийн дотор халаалтын шугамын засварын ажил; 19 дүгээр хороо, Нийгмийн даатгалын хэлтсийн гадна дулаан болон цэвэр усны шугам солих ажил тус тус бүрэн хийгдэж дууссан.	100%
БҮЛГИЙН ДУНДАЖ ХУВЬ												98%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ												91%